



Гүйцэтгэлийн аудитын тайлан

***ТӨРӨӨС СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ТАЛААР
БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО ОНОВЧТОЙ ҮР ДҮНТЭЙ
БАЙНА.***

**АУДИТЫН СЭДЭВ: ТӨРӨӨС СУРГУУЛИЙН
ӨМНӨХ БОЛОВСРОЛ ОЛГОЖ БАЙГАА
ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ҮР ДҮН**



АГУУЛГА

Хүснэгтийн товчг	5
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	6
БҮЛЭГ 1. ТӨРӨӨС СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ТАЛААР БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТОГТОЛЦОО ОНОВЧТОЙ БАЙГАА ЭСЭХ	8
ТӨРӨӨС СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ТАЛААР БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО ОНОВЧТОЙ ҮР ДҮНТЭЙ БАЙНА	8
А.1. СӨБ олгох үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуульд заасны дагуу субъект нь зарим журмыг батлаагүй, батлагдсан журмын зарим заалт хоорондоо зөрчилдөж байна	8
А.1.1. СӨБ олгох үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид заагдсан эрх бүхий субъект нь зарим дүрэм, журмыг батлаагүй, батлагдсан зарим журам, хөтөлбөр нь хоорондоо зөрчилдөж байна	8
А.1.2. СӨБ-ийн талаар төрөөс авч хэрэгжүүлж байгаа бодлого харилцан уялдаатай төлөвлөгдөж байгаа боловч тоо хэмжээний хувьд зөрүүтэй байна	11
А.2 СӨБ-ын бодлогыг талаар төрөөс хэрэгжүүлэх удирдлагын болон санхүүгийн тогтолцоо чиг үүрэг нь хуульд заасны дагуу зохион байгуулагдсан байна	14
А.2.1. Орон нутгийн түвшинд СӨБ-ын бодлого хариуцаж буй бүтэц, түүний ажлын чиг үүргийг хуульд заасны дагуу оновчтой зохион байгуулжээ	14
А.2.2. СӨБ-ийн байгууллагуудын санхүүжилтийн тогтолцоо нь Төсвийн тухай хуульд заасан зарчмын дагуу явагдаж байгаа ба чиг үүргийг хэрэгжүүлэх бүтцийг оновчтой зохион байгуулсан байна	16
ОРОН ТООНЫ БОЛОН НЭГ ХҮҮХДЭД НОГДОХ ХУВЬСАХ ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ БАЙДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙЖ ТӨСВИЙН ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ БАЙНА	16
БҮЛЭГ 2. БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ ҮР НӨЛӨӨТЭЙ, ҮР ДҮНТЭЙ БАЙНА УУ?	16
Б.1 СӨБ-д олгох үйлчилгээг бодитой төлөвлөж төрөөс СӨБ-ийн хамрагдалтыг сайжруулах бодлого барьж ажилласнаар хамрагдалт хүртээмж сүүлийн 3 жилд өссөн байна	17
Б.1.1. Шинээр баригдсан цэцэрлэгүүдийн анги дүүргэлт хангалттай байгаагаас үзэхэд хүн амын нягтрал, өрхийн тоонд уялдуулан төлөвлөжээ	17
Б.1.2. 2016-2018 онд Баянхонгор суманд шинээр баригдаж ашиглалтад орсон цэцэрлэгүүд нь хэрэгцээ шаардлагын дагуу аймгийн ерөнхий төлөвлөгөөнд бүрэн туссан байна	19
Б.1.3. СӨБ-д хамрадаж буй хүүхдийн тоо нь сүүлийн 3 жилд өсөлттэй байгаа нь төрөөс СӨБ-ийн хамрагдалтыг сайжруулах бодлого барьж ажиллаж байгаа нь нөлөөлж байна	20
Б.1.4 СӨБ-ийг цөм хөтөлбөрийн дагуу хөдөлгөөн эрүүл мэнд, зан чанар, хэл яриа, байгаль орчин, математик, дүрслэх урлаг зэрэг чиглэлээр чадвар эзэмшүүлж байна	22
Б.2. Хөдөө сумдад мэргэжлийн боловсон хүчний хүрэлцээ хангалтгүй дутмаг байгаагаас СӨБ багшид тавих шаардлагыг хангаагүй, мэргэжлийн бус багш ажиллуулж байна	24
Б.2.1. Мэргэжлийн боловсон хүчний хүрэлцээ хангалтгүй дутмаг байгаагаас өндөр насны тэтгэвэрт гарсан, мэргэжлийн бус багшийг ажиллуулсан байна	24
Б.2.2. Сургуулийн өмнөх боловсролын тухай 12.1 -т заасныг зөрчиж СӨБ багшид тавих шаардлагыг хангаагүй мэргэжлийн бус багшийг ажиллуулсан байна	25
Б.3 СӨБ-ын үйл ажиллагаанд олгож байгаа зардлыг зориулалтын дагуу зарцуулсан байна	27
Б.3.1. СӨБ-ын байгууллагуудын төсвийн орлогыг Засгийн газраас тогтоосон нэг хүүхдэд ногдох нормативыг баримталж төлөвлөсөн байна	27
3.2. СӨБ-ын байгууллага нь зардлыг зориулалтын дагуу ашигласан боловч төсвийн үр ашгийг сайжруулах, хөрөнгө оруулалтын бодлоготой уялдуулан зардлыг төлөвлөх шаардлагатай байна	29
Б.4. СӨБ-ын үйл ажиллагаанд аймгийн БСУГ-аас жилд 2 удаа хяналт хийж, арга зүйн зөвлөгөө өгч ажилладаг боловч хяналт шалгалтын тайлангүй, хяналт шалгалтын мөрөөр хийж хэрэгжүүлэх ажлын зөвлөмжийг цэцэрлэгт хүргүүлж биелэлтийг тооцож ажиллаагүй байна	32



Б.4.1. Зарим цэцэрлэгийн удирдлагууд Засгийн газрын 2015 оны 311 дүгээр тогтоолын дагуу “Дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам” боловсруулаагүй, ажлын төлөвлөгөө гарган төлөвлөгөөний биелэлтийг тайлагнаж ажиллаагүй байна.....32

Б.4.2. СӨБ-ын үйл ажиллагаанд аймгийн МХГ нь төлөвлөгөөт шалгалтыг байнга хийж ажилласан бөгөөд харин БСУГ-аас жилд 2 удаа хяналт хийж, арга зүйн зөвлөгөө өгч ажилладаг гэх боловч хяналт шалгалтын тайлангүй, хяналт шалгалтын мөрөөр хийж хэрэгжүүлэх ажлын зөвлөмжийг цэцэрлэгт хүргүүлж ажиллаагүй байна.35

Холбогдох байгууллагын санал:.....40

Саналд өгсөн тайлбар:.....43

ДҮГНЭЛТ: 44

ЗӨВЛӨМЖ: 45

ХАВСРАЛТУУД:.....Error! Bookmark not defined.



Товчилсон үгийн тайлбар

УИХ	УИХ	Улсын их хурал
ЗГ	ЗГ	Засгийн газар
БСШУ	БСШУ	Боловсрол соёл шинжлэх ухаан
БСШУ	БСШУ	Боловсрол соёл шинжлэх ухаан спортын
ШУБС	ШУБС	Шинжлэх ухаан боловсрол сайд
ШУБС	ШУБС	Шинжлэх ухаан боловсрол сайд
БСШУСС	БСШУСС	Боловсрол соёл шинжлэх ухаан спортын
ИТХ	ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
БСУГ	БСУГ	Боловсрол соёл урлагийн газар
МХГ	МХГ	Мэргэжлийн хяналтын газар
СТСХ	СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
АА	АА	Аж ахуй
ЕБС	ЕБС	Ерөнхий боловсрол сургууль
СӨБ	СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ЗГҮАХХАХТ	ЗГҮАХХАХТ	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр хэмжээний төлөвлөгөө
МУТХҮБ-	МУТХҮБ-	Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл б
ЗГҮАХ	ЗГҮАХ	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
СӨБ	СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
УТХО	УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ОНХС	ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
НДШ	НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл



Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт № 1	СӨБ-ын дагаж мөрдөж буй хуулийн дагуу батлагдаагүй дүрэм журам	10
Хүснэгт № 2	Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, урт, дунд хугацааны бодлогын уялдаа	12
Хүснэгт № 3	Монгол улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн уялдаа холбоо	13
Хүснэгт № 4	Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн уялдаа холбоо	14
Хүснэгт № 5	Чиг үүргийн хоорондын уялдаа холбоо	
Хүснэгт № 6	Шинээр баригдсан цэцэрлэгт хамрагдсан хүүхдийн судалгаа	18
Хүснэгт № 7	Шинээр баригдсан цэцэрлэгийн сургалтын орчны үнэлгээ	20
Хүснэгт № 8	Аймгийн хэмжээний СӨБ-д хамрагдсан хүүхдийн судалгаа	21
Хүснэгт № 9	Хувийн өмчийн цэцэрлэгт олгосон санхүүжилтийн судалгаа	22
Хүснэгт № 10	Түүвэрт хамрагдсан цэцэрлэгийн ахицын үнэлгээ	23
Хүснэгт № 11	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад ажиллаж байгаа багш, ажиллагчид	24
Хүснэгт № 12	2016-2018 онд олгосон мөнгөн тэтгэмж	25
Хүснэгт № 13	Батлагдсан төсвийг хувьсах зардалтай харьцуулсан судалгаа	28
Хүснэгт № 14	Бүлгийн тоог орон тоотой харьцуулсан судалгаа	28
Хүснэгт № 15	СӨБ-ын төсвийн гүйцэтгэлийн нэгтгэл	29
Хүснэгт № 16	Зах зээлийн үнийн судалгаа	30
Хүснэгт № 17	СӨБ-ын төсөв хоорондын үр ашгийн судалгаа	31
Хүснэгт № 18		

Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл №1	СӨБ-д хамрагдаж байгаа хамрагдалтын хэлбэр	22
Дүрслэл №2	Бэлтгэл бүлгийн хүүхдийн 2017 оны стандарт хангалтын үнэлгээ	23
Дүрслэл № 3	Нэг багшид ногдох хүүхдийн тоо, хамран сургалтын бохир жин 2016-2018 он	24
Дүрслэл № 4	Мэргэшүүлэх сургалтын хамрагдалт	27
Дүрслэл № 5	Улсын цэцэрлэгт хүүхэд нь хамрагдаж буй эцэг эхчүүдээс авсан судалгаа	28
Дүрслэл № 6	Хувийн өмчийн цэцэрлэгт хүүхэд нь хамрагдаж буй эцэг эхчүүдээс авсан судалгаа	28

Хавсралтын товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт №1	Улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл тусламж хандивын хөрөнгөөр 2016-2018 онд ашиглалтанд орсон цэцэрлэгүүдийн судалгаа	46
Хавсралт №2	Хувийн өмчийн цэцэрлэгүүдийн судалгаа	47
Хавсралт № 3	Төрийн өмчийн цэцэрлэгүүдийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн судалгаа	48-52

**Аудит хийх
үндэслэл, бүрэн
эрх****Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх
мэдэгдэл**

Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2019 оны 04 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов "Аудитын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай" 2019 оны А/45 дугаар тушаалын дагуу "Төрөөс сургуулийн өмнөх боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүн"-д Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв

Аудитын зорилт

Төрөөс сургуулийн өмнөх боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүнд улсын хэмжээнд нэгдсэн удирдамжаар аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Төрөөс сургуулийн өмнөх боловсролын талаар баримталж буй бодлогыг хэрэгжүүлэх тогтолцоо оновчтой байгаа эсэх;
- Бодлогын хэрэгжилт үр нөлөөтэй, үр дүнтэй байгаа эсэх;

**Аудитын хамарсан
хүрээ**

Аудитыг БСШУСЯ, ЭМЯ, БХБЯ, ХНХЯ, Сангийн яам, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Барилгын хөгжлийн төв, аймаг, нийслэлийн ЗДТГ, хот байгуулалт, хөгжлийн асуудал, Газар зохион байгуулалт хариуцсан харьяа агентлаг байгууллагууд, Боловсролын газар, төрийн болон хувийн өмчийн цэцэрлэгүүдийн 2016-2018 оны үйл ажиллагааг /сүүлийн 3 хичээлийн жил/ хамруулан гүйцэтгэлээ.

**Аудитын
хязгаарлалт**

.....

**Аудитын арга зүй,
шалгуур үзүүлэлт**

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 300, 3000-3100 үндэслэн боловсруулсан Гүйцэтгэлийн аудитын журамд заасан арга зүйг ашиглан Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, байгууллагын худалдан авалт хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон зээл олголт, санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материал, сүүлийн 6 жилийн байдлаарх үндсэн үзүүлэлтийн судалгаанд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, бөгөөд тэргүүлэх аудитор Б.Мөнхбат удирдаж, аудитын менежер А.Цээням чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Азбаяр, аудитор Г.Ганчимэг, Н.Бүнчинсүрэн нар хамтран гүйцэтгэв.

Аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг 2019 оны 09 дүгээр сарын 18-ний өдөр батлуулж, талбарын ажлыг 2019 оны 09 дугаар сарын 18-ны өдрөөс 2019 оны 10 дугаар сарын 17-ний өдөр хүртэл гүйцэтгэж аудитын тайланг холбогдох үе шатны хяналтаар хянуулан Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулж, 2019 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр ҮАГ-ын ГАГ-т болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв.

Хүндрэл бэрхшээл

.Байхгүй.



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДЭД ТАЙЛАН

**БҮЛЭГ 1. ТӨРӨӨС
СУРГУУЛИЙН ӨМНӨХ
БОЛОВСРОЛЫН ТАЛААР
БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГЫГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ТОГТОЛЦОО
ОНОВЧТОЙ БАЙГАА ЭСЭХ**

ТӨРӨӨС СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ТАЛААР БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО ОНОВЧТОЙ ҮР ДҮНТЭЙ БАЙНА.

А.1. СӨБ олгох үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуульд заасны дагуу субъект нь зарим журмыг батлаагүй, батлагдсан журмын зарим заалт хоорондоо зөрчилдөж байна.

А.1.1. СӨБ олгох үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид заагдсан эрх бүхий субъект нь зарим дүрэм, журмыг батлаагүй, батлагдсан зарим журам, хөтөлбөр нь хоорондоо зөрчилдөж байна.

1 Сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 16.7 дахь хэсэгт “сурч боловсрох эрхтэй...”, Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль болон дээрх хуулиудыг дагаж гарсан дүрэм, журам норм стандартаар зохицуулагдан холбогдох хууль, эрх зүйн орчин бүрдсэн байна.

Дээрх эрх зүйн зохицуулалтуудын харилцан уялдаа холбоог авч үзэхэд зарим зүйл заалтууд хоорондоо зөрчигдөж байна. Тухайлбал:

Аудитын илрүүлэлт

1. БСШУ-ны сайдын 2012 оны А/131 тоот тушаалаар “Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх хувилбарт сургалтыг зохион байгуулах журам”-ын 5.2.3-т хувилбарт сургалтын цагийн жишиг доод хэмжээг “3 настай хүүхдэд жилд 240 цаг, 4 настай хүүхдэд жилд 280 цаг, 5 настай хүүхдэд жилд 360 цаг” байна гэж заасан байхад БШУ-ны /тухайн үеийн/ сайдын 2013.08.28-ний өдрийн А/327 тоот тушаалаар баталсан “Сургуулийн өмнөх боловсролын сургалтын зохион байгуулалт”-ыг батлахдаа хувилбарт сургалтын нэг хичээлийн жилд 200 цаг байхаар батлахдаа өмнөх тушаалыг хүчингүй болгоогүй.
2. БСШУ-ны сайдын 2015 оны А/301 тоот тушаалаар батлагдсан Сургалтын цөм хөтөлбөрт: суралцахуйн 6 чиглэл байгаа боловч БСШУЯ сайдын 2014 оны А/493 дугаар тушаалаар батлагдсан “Сургуулийн өмнөх боловсролын сургалтын зохион байгуулалт”-д суралцахуйн гэсэн 5 чиглэл болгон тусгасан.

2 Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай, Багшийн хөгжлийн дэмжих тухай хуульд заасны дагуу Засгийн газар, Засгийн газрын гишүүн, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бусад холбогдох эрх бүхий байгууллагаас баталж гаргавал зохих дүрэм журмын жагсаалтыг гаргаж үзэхэд зарим журмуудыг батлаагүй байна. Тухайлбал:



№	Холбогдох хууль	Хуулийн дагуу дүрэм журам батлагдаагүй, хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлээгүй
1	Боловсролын хууль тухай	25.6.Энэ хуулийн 25.2¹-т заасныг хэрэгжүүлэхтэй холбоотой дүгнэлт гаргах аргачлал, журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” 39.7.Орон нутгийг боловсон хүчнээр хангах, чухал хэрэгцээтэй мэргэжилтэн бэлтгэх, суралцагчийн авьяасыг дэмжих, орлого багатай болон хөгжлийн бэрхшээлтэй ирээдэд боловсрол эзэмшихэд зориулж сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж олгох бөгөөд тэдгээрийг олгох журмыг Засгийн газар батална. 39.12.Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг өөрийн үйл ажиллагаанаас орлого олох, түүнийг зарцуулах, тайлагнах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.
2	Сургуулийн боловсролын хууль өмнөх тухай	7.1.Хүүхдийн чадвар, чадамж, хөгжлийн ахицыг үнэлэх журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. 8.6.Тусгай, гэр цэцэрлэг болон сувицлын цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм, эрүүл ахуй, ариун цэврийн дүрмийг эрүүл мэнд, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, асрамжийн болон халамжийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрмийг боловсролын болон нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална. 9.16.Энэ хуулийн 9.15-д заасан нэмэгдэл цалингийн хэмжээ, түүнийг олгох журмыг Засгийн газар батална. /9.15.Цэцэрлэгийн багшид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, ажил, мэргэжлийн онцлогоос шалтгаалан нэмэгдэл цалин олгоно./
3	Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль	13.1.Багшийн ёс зүйн хорооны дүрмийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална. 11.3.Багшид ажлын гүйцэтгэлд суурилсан урамшууллыг олгох бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална. 9.2.Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, мэргэжлийн сургалт, боловсролын сургалтын байгууллагын багшийн мэргэжлийн зэргийг суралцагчдын сурлагын амжилт, чанар, суралцагч, эсхүл түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн сэтгэл ханамж, заах аргын чадвар, өөрийгөө хөгжүүлсэн байдлыг харгалзан хугацаанаас өмнө нэмэгдүүлж болох бөгөөд холбогдох журмыг боловсролын болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална. 8.3.Багш мэргэжлээр дээд боловсрол олгох их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт 6 сарын хугацаатай дадлагажигч багшаар ажиллах агуулгыг багтаана. Дадлагажигч хөдөө орон нутагт ажиллавал тэтгэлэг олгож болох бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална. 7.5.Багшийн хөгжлийн төвд тавигдах шаардлага, ажиллах үлгэрчилсэн журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

Дээрх байдлаас үзэхэд хуулиудын холбогдох заалтыг хэрэгжүүлээгүй байх тул холбогдох эрх зүйн дүрэм, журмыг бүрэн батлуулах зөвлөмжийг холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх саналыг ҮАГ-т хүргүүлэв.

з Аудитаар хамрагдаж буй цэцэрлэгүүдийн сургалтын хөтөлбөр баталсан байдалтай танилцахад 2016-2018 онуудад цөм хөтөлбөрт уялдуулан сургалтын хөтөлбөр боловсруулж батлуулсан байна. Харин Жинст, Бууцагаан, Бөмбөгөр, Галуут, Эрдэнэцогт, Өлзийт сумдын цэцэрлэгүүд нь Цөм хөтөлбөрөөр 2016 онд

¹ 25.2.Боловсролын сургалтын байгууллагыг энэ хуулийн 25.1.1-д заасны дагуу татан буулгах шийдвэр гарахаас 2 сарын өмнө тухайн боловсролын сургалтын байгууллагыг татан буулгах ажлын төлөвлөгөө, авах арга хэмжээний талаарх саналаа холбогдох тооцоо, судалгааны хамт боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх бөгөөд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага уг саналыг судлан дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргана



сургалтын хөтөлбөрийг баталж, дараагийн онуудад шинэчлэн батлаагүй, өмнөх жишиг сургалтын хөтөлбөрөө баримталж ажилласан байна.

Аймгийн БСУГ-аас 2019 онд 2016-2018 оны эхний хагас жилийг хамруулан СӨБ-ын сургалтын цөм хөтөлбөрийн “агуулга”-д хийсэн шинжилгээ хийсэн материалыг авч үзэв. Тус шинжилгээнд дурдсанаар:

1. Сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн агуулгатай холбоотой суралцахуйн чиглэлийн нэршлийн ойлгомжтой байдал

- Цөм хөтөлбөрийн суралцахуйн чиглэл нь зургаан чиглэлтэй байхад үнэлгээ нь долоон чиглэлээр гарсан. */Хэл яриа, харилгаа гэсэн чиглэлийг үнэлгээнд оруулахдаа Хэл яриа болон Орчноо таньж мэдэх орчинтой танилцах гэж салгасан/*
- Суралцахуйн чиглэлд Зан чанар харилцааг оруулсан боловч хэрэгжүүлэх явцад бүх агуулгад шингээхээр шийдвэрлэсэн.
- Дүрслэх урлаг, хөгжим суралцахуйн чиглэлийг нэг агуулгаар оруулсан
- Дүрслэх урлаг суралцахуйн чиглэлд урлагийн бүтээлтэй танилцуулах чиглэл орхигдсон.
- Хөдөлгөөн эрүүл мэнд суралцахуйн чиглэлд зөв зохистой хооллолтын талаар дутмаг
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах агуулга арга зүйн асуудал орхигдсон.
- Цөм хөтөлбөрт эцэг эхийн оролцоог хэрхэн оролцох талаар орхигдуулсан.

Тус агуулгын шинжилгээний дүгнэлтэд Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн “агуулга”, “стандарт” гэх нэр томъёогоор илэрч байгаа зохицуулалтын шинжтэй агуулгад цөм хөтөлбөрийн зориулалт нийцсэн байна гэж дүгнэжээ.

4 Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 8.5²-т заасны дагуу БШУ-ны сайдын 2005 оны 405 тоот тушаалаар дүрмийг баталсан бөгөөд сайдын 2019 оны А/118 тоот тушаалаар “Цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм”-ийг шинэчлэн баталсан байна.

Аудитаар аймгийн хэмжээний 26 цэцэрлэгийн дүрмийг авч үзэхэд зарим сумд дүрмээ батлаагүй, зарим сумдын цэцэрлэг огт байхгүй байгаа нь дээрх сайдын тушаалыг хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал:

Аудитын илрүүлэлт

Богд, Баацагаан сумд дүрэм боловсруулсан боловч баталгаажуулаагүй, Жинст, Баян-Овоо, Бууцагаан сумын Баянбүрдийн бага цэцэрлэг нь цэцэрлэгийн дүрэм боловсруулж батлаагүй байна. Иймд дүрэм батлаагүй дээрх цэцэрлэгүүдийн эрхлэгч нарт цэцэрлэгийн дүрмийг боловсруулж батлуулах арга хэмжээ авч ажиллахыг аймгийн БСУГ-т хүргүүлэв.

Мөн цөм хөтөлбөрийн хүрээнд цэцэрлэг бүр өөрийн онцлог давуу тал дээр суурилан хүүхэд бүрийн ахиц амжилтыг урамшуулан, өөртөө итгэлтэй, эрүүл чийрэг,

² 8.5²-д “Цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм болон аюулгүй байдлын дүрмийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална”



зөв дадал хэвшил, зан чанартай, шинжлэх ухааны суурь мэдлэг чадвартай, сурах арга барил, суралцах хүсэл эрмэлзэлтэй болж хөгжин төлөвшихөд дэмжих зорилгоор хүүхдэд өдөр тутамд шаардлагатай бие бялдрыг хөгжүүлэх болон эрүүл мэндийн дадал чадварыг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж ажиллажээ. Тухайлбал:

Баянхонгор аймгийн 9 дүгээр цэцэрлэгийн хувьд “Хүүхэд хөгжих таатай орчинд хүүхэд бүрийн хөгжлийг дэмжинэ, тэдний урлан бүтээх, өөртөө үйлчлэх чадварыг чухалчилна” хэмээн эрхэм зорилгыг тодорхойлж бүлэг бүр өөр өөрийн онцлогтой орчин бүрдүүлж, хүүхэд хөдөлгөөнтэй байх, хөдөлгөөний чадвар сайжрах сургалтын хэрэгслэгдэхүүн, шат зэргийг байршуулжээ.

Мөн Баянхонгор аймгийн 4 дүгээр цэцэрлэг нь хүүхдийн бие сэтгэлийн эрүүл мэндийг эрхэмлэн хүүхэдтэй ажиллахдаа үлгэрлэн дагуулах ардын уламжлалт арга, тоглоомын аргыг чухалчлан ажиллавал хүүхэд бүрийг боломжит дээд хурдаар нь хөгжүүлнэ гэж тодорхойлсон байна

А.1.2. СӨБ-ийн талаар төрөөс авч хэрэгжүүлж байгаа бодлого харилцан уялдаатай төлөвлөгдөж байгаа боловч тоо хэмжээний хувьд зөрүүтэй байна.

5 СӨБ-ийн урт болон дунд хугацааны бодлогыг УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ийн Мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий Монгол хүн” хэсгийн 2.2.3, УИХ-ын 2015 онд 12 дугаар тогтоолоор “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого батлах тухай” баримт бичигт тус тус тусгасан байна. Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт СӨБ-ийн талаар авч хэрэгжүүлэх хөтөлбөрийг дээрх баримт бичгүүдтэй уялдсан эсэх талаар авч үзэв.

Хүснэгт №2: Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, урт, дунд хугацааны бодлогын уялдаа

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030	Төрөөс боловсролын талаар 2014-2024 онд баримтлах бодлого	Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт
2.2.3. Мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий Монгол хүн <u>Зорилт1.</u> Хүүхэд бүрийг стандартын шаардлага хангасан сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулж, монгол хэл, сэтгэлгээний үндсийг эзэмшүүлнэ. 1 шат (2016-2020): Сургуулийн өмнөх боловсролын тогтолцооны төрөл хэлбэрийг өргөтгөж, хүртээмж, чанарыг сайжруулан сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд сургуулийн өмнөх насны нийт хүүхдийн 70 хувийг хамруулах нөхцөл бүрдүүлэх.	3.2. Сургуулийн өмнөх боловсролыг “хүүхдийг сургах, сургуульд бэлтгэх” гэсэн зорилгоос илүүтэйгээр хүний хөгжлийн үндэс, өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжих, насан туршийн боловсролын суурь үе хэмээн хөгжүүлнэ. 4.8. Сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд боловсролын стандарт, цөм хөтөлбөрийг төрөөс тогтоож, чанар, үр дүнг үнэлнэ. 6.7. Сургуулийн өмнөх боловсролын үндсэн зардлыг төрөөс санхүүжүүлж, хоолны зардлыг эцэг эх, асран хамгаалагч нь хуваалцах зарчмыг баримтална 7.6. Монгол хүүхэд бүр үндсэн, цагийн, улирлын, ээлжийн, явуулын багшийн, нүүдлийн зэрэг хэлбэрээр сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдсан байна. 7.11. Боловсролын удирдлага, мэдээллийн нэгдсэн системийг 2016-2017 оны хичээлийн жилээс үндэсний хэмжээнд бүрэн нэвтрүүлсэн байна.	3.2.2.“Хүүхэд бүр цэцэрлэгт” хөтөлбөрийг хэрэгжүүлж хот суурин газарт хүүхэд бүр цэцэрлэгт хамрагдах боломжийг бий болгоно. 3.2.3.Анги дүүргэлт хэт өндөртэй сургууль, цэцэрлэгийн ачааллыг бууруулж, 3 ээлжтэй сургуулийг 2 ээлжид шилжүүлнэ. 3.2.5.“Байгууллагын цэцэрлэг”-ийн хууль, эрх зүйн орчин бүрдүүлж, татварын бодлогоор дэмжинэ. 3.2.7.Цэцэрлэг, сургуулийн орчин гэрэлтүүлэг, гарц, гэрлэн дохио, камер, автомашины хурд сааруулагчтай болгоно.

Аудитын илрүүлэлт:



Дээрх бодлогын баримт бичгүүдийн үндсэн үзэл санаа нь хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулах талаар тусгасан бөгөөд дунд хугацаанд хөтөлбөрт 70 хувь хамруулахаар тусгасан байхад МУ-ын Засгийн газар нь хүүхэд бүрийг цэцэрлэгт хамруулахаар тусгасан нь тоо хэмжээний хувьд уялдаа холбоогүй байна гэж үзэхээр байна.

Мөн аймгийн Засаг дарга хүүхдийг 100 хувь цэцэрлэгт хамруулах гэрээг эрхлэгч нартай хийдгээс болж цэцэрлэгийн даац хэтрэх хүүхдийн эрүүл аюулгүй орчин эрсдэл орох гол нөхцөл болж байгаа ба зарим цэцэрлэг үүнийг ашиглан төсөвт нэмэлт зардал гаргах гэх мэт зохисгүй үзэгдэл гаргаж байна.

6 Монгол улсын нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд салбарын яамны бодлогыг тусгаж УИХ-аар батлуулж байгаа бөгөөд авч хэрэгжүүлэх зорилт арга хэмжээг урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөртэй уялдуулан баталж байна.

Төрөөс сургуулийн өмнөх боловсролын талаарх бодлогыг дээрх баримт бичигт тусгаж урт болон дунд хугацааны бодлоготой уялдуулан боловсруулжээ.

Хүснэгт № 3: Монгол улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн уялдаа холбоо

Монгол улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл	Заалт	Үндсэн чиглэлд тусгагдсан Зорилт, арга хэмжээ	Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр	Урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг
Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	15.10	Хүүхдийн хөгжил, төлөвшлийг хангах зорилгоор “Зөв Монгол хүүхэд” үндэсний хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Зорилт 15. Хүүхэд, сурагч, оюутан нэг бүрийг хөгжүүлж, багш нарын ур чадварыг дээшлүүлнэ.	ЗГҮАХХАХТ-ний 187.8, 187.9 дэх заалт
Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	11.1	“Хүүхэд бүр цэцэрлэгт” хөтөлбөрийг хэрэгжүүлж, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын хувийг нэмэгдүүлэх	Зорилт 11. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын эрх зүйн орчныг сайжруулж, боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, ая тухтай сурч, боловсрох орчныг бүрдүүлэх бодлого хэрэгжүүлнэ	МУТХҮБ-2030-ын 2.2.3, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 3.2.2, 3.2.5 дахь заалт
Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	10.6	Хүүхэд бүрийг цэцэрлэгт хамруулах зорилгоор 2018 оноос тодорхой мөнгө хуваарилах, ,,	Зорилт 10. Боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, ая тухтай сурч, боловсрох орчин бүрдүүлэх бодлого хэрэгжүүлнэ. 10.6	МУТХҮБ-2030-ын 2.2.3, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 3.2.2 дахь заалт
	10.9	Цэцэрлэгийн туслах болон асрагч багш нарыг мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвөөр бэлтгэх		МУТХҮБ-2030-ын 2.2.1, зорилт 2, ЗГҮАХ-ийн 3.3.10 дахь заалт
	10.12	Сургууль, цэцэрлэгийн 80 хувиас дээш гүйцэтгэлтэй дутуу барилгын санхүүжилтийг шийдвэрлэж, ашиглалтад оруулах		ЗГҮАХ-ийн 3.2.2 дахь заалт

7 Аймгийн Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөр, аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд СӨБ-ийн талаар хэрэгжүүлэх бодлогыг тусгасан байна. Орон нутагт авч хэрэгжүүлж буй СӨБ олгох үйлчилгээ нь Засгийн



газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Монгол Улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөртэй уялдаж байна.

Аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 2016, 2017, 2018 онуудын үндсэн чиглэлийн хэрэгжилтэд СӨБ-той холбоотой дээрх заалтуудыг бүрэн хэрэгжүүлсэн гэж дүгнэсэн байна.

Үндсэн чиглэлд тусгасан арга хэмжээг ЗГ-ын мөрийн хөтөлбөр, Монгол улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөртэй уялдаж буй эсэхийг авч үзвэл:

Хүснэгт № 4: Баянхонгор аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн уялдаа холбоо

Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл	Аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан Зорилт, арга хэмжээ	Аймгийн Засаг даргын 2016-2020 оны ажиллагааны мөрийн хөтөлбөр	Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр
Аймгийн эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	Зорилт 13. Сургууль, цэцэрлэгийн материаллаг баазыг хөгжүүлж, багшлах боловсон хүчний ур чадварыг дээшлүүлэн хүүхэд бүрийн авьяасыг хөгжүүлнэ.	10. Хүүхэд харах үйлчилгээг дэмжиж, шинээр цэцэрлэг барих, шаардлагатай цэцэрлэгүүдийн байрыг өргөтгөх, иргэд, аж ахуйн нэгж байгууллага, хувийн хэвшлийн сургууль цэцэрлэг байгуулах асуудлыг бодлогоор дэмжих замаар сургуулийн өмнөх насны хүүхдүүдийг цэцэрлэгт 100 хувь хамруулна.	Зорилт 11.
	13.1-13.8 цэцэрлэгийн материаллаг хангамжийг сайжруулах	12. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулиудын багш нарын мэргэжил, авьяас, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх зорилгоор жил бүр шалгаруулалт явуулж, нийгмийн асуудлыг шийдвэрлэх тогтвор суурьшилтай ажиллуулах “Сайн багш” хөтөлбөр хэрэгжүүлж, 100- аас доошгүй багшийг гадаадад давтан сургаж, жилд 10 сая хүртэл төгрөгийн эх үүсвэр бүхий санг бий болгож урамшуулна.	Зорилт 15.
Аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл /Б.Боловсрол/	11. Хүүхэд харах үйлчилгээнд мониторинг хийж үйлчилгээний чанарыг сайжруулах, цэцэрлэгүүдийн тоог нэмэгдүүлэх, шаардлагатай цэцэрлэгүүдийн байрыг өргөтгөх, төр хувийн хэвшлийн байгууллагуудыг өөрийн харьяаны цэцэрлэг байгуулах асуудлыг дэмжих	10. Хүүхэд харах үйлчилгээг дэмжиж, шинээр цэцэрлэг барих, шаардлагатай цэцэрлэгүүдийн байрыг өргөтгөх, иргэд, аж ахуйн нэгж байгууллага, хувийн хэвшлийн сургууль цэцэрлэг байгуулах асуудлыг бодлогоор дэмжих замаар сургуулийн өмнөх насны хүүхдүүдийг цэцэрлэгт 100 хувь хамруулна.	Зорилт 11.
	12. “Чандмань-Баянхонгор” компанийн ажилчдын 50 хүүхдийн цэцэрлэг барих. Аймгийн ЗДТГ-ын буудлын барилгыг засварлан 60 хүүхдийн цэцэрлэг өөрчлөн байгуулах	12. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулиудын багш нарын мэргэжил, авьяас, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх зорилгоор жил бүр шалгаруулалт явуулж, нийгмийн асуудлыг шийдвэрлэх тогтвор суурьшилтай ажиллуулах “Сайн багш” хөтөлбөр хэрэгжүүлж, 100- аас доошгүй багшийг гадаадад давтан сургаж, жилд 10 сая хүртэл төгрөгийн эх үүсвэр бүхий санг бий болгож урамшуулна.	Зорилт 15.



Аймгийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	16-17. СӨБ-ын хамран сургалтыг нэмэгдүүлэх, шаардлагатай цэцэрлэгүүдийн байрыг шинээр барих	10.Хүүхэд харах үйлчилгээг дэмжиж, шинээр цэцэрлэг барих, шаардлагатай цэцэрлэгүүдийн байрыг өргөтгөх, иргэд, аж ахуйн нэгж байгууллага, хувийн хэвшлийн сургууль цэцэрлэг байгуулах асуудлыг бодлогоор дэмжих замаар сургуулийн өмнөх насны хүүхдүүдийг цэцэрлэгт 100 хувь хамруулна.	Зорилт 11.
	18. Шаардлагатай цэцэрлэгүүдэд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар засвар хийлгэнэ.		
	38. Сургууль, цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчлэх, цахилгааны монтажийг хийх		
	19. “Сайн багш” хөтөлбөрийг хэрэгжүүлэх	12.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулиудын багш нарын мэргэжил, авьяас, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх зорилгоор жил бүр шалгаруулалт явуулж, нийгмийн асуудлыг шийдвэрлэх тогтвор суурьшилтай ажиллуулах “Сайн багш” хөтөлбөр хэрэгжүүлж, 100- аас доошгүй багшийг гадаадад давтан сургаж, жилд 10 сая хүртэл төгрөгийн эх үүсвэр бүхий санг бий болгож урамшуулна.	Зорилт 15.
	20.Сайн багш хөтөлбөрийн хүрээнд багш нарын түвшинг тогтоох		
	21. Сайн багш хөтөлбөрийн хүрээнд “Сайн багш” тодруулах аргачлал, журмыг боловсруулах		
	25. “Хос бичигтэн” хөтөлбөрийг хэрэгжүүлэх	11.Хүүхдийг цэцэрлэгээс эхлэн авьяас чадварыг нээхэд нь туслах зорилгоор хүүхдийн ухаан сэтгэхүйг хөгжүүлэхэд чиглэгдсэн “Үндэсний онцлогтой тоглоом”-ын үйлдвэр байгуулж, аймгийн бүх цэцэрлэгийг хангана.	Зорилт 15.
	22. “Мазаалай” “12 жил” бага насны хүүхдийн буддаг номыг сургалтад ашиглах асуудлыг судалж шийдвэрлэх		

А.2 СӨБ-ын бодлогыг талаар төрөөс хэрэгжүүлэх удирдлагын болон санхүүгийн тогтолцоо чиг үүрэг нь хуульд заасны дагуу зохион байгуулагдсан байна.

А.2.1. Орон нутгийн түвшинд СӨБ-ын бодлого хариуцаж буй бүтэц, түүний ажлын чиг үүргийг хуульд заасны дагуу оновчтой зохион байгуулжээ.

8 Боловсролын тухай хуулийн 27.1³-т боловсролын удирдлагын тогтолцоог тодорхойлсон байна. Аймагт боловсролын асуудал эрхэлсэн байгууллага нь Боловсролын тухай хуулийн 27.2⁴.заасны дагуу БСУГ хэрэгжүүлж ирсэн бөгөөд тус газрын даргыг БШУ-ны сайдын зөвшөөрснөөр аймгийн Засаг дарга томилж, чөлөөлж үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллаж иржээ.

Аймгийн БСУГ-ын чиг үүргийг Боловсролын тухай хуулийн 16.2⁵-т тодорхойлсноор СӨБ-ын байгууллагад удирдлагын болон мэргэжлийн туслалцаа үзүүлнэ гэж тусгажээ. Аймгийн БСУГ-ын бүтэц зохион байгуулалтын схемийг аймгийн Засаг дарга 2017 оны А/65 тоот захирамжаар зохион байгуулсан бөгөөд тус схемээр 3 хэлтэстэй байхаар зохион байгуулжээ.

³ Боловсролын удирдлага нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, боловсролын байгууллагын болон түүний өөрийн удирдлагаас бүрдэнэ

⁴ Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь аймаг, нийслэлд боловсролын газар, нийслэлийн дүүрэгт боловсролын хэлтэс байна.

⁵ 16.2.Аймаг, нийслэлийн боловсролын газар, нийслэлийн дүүргийн боловсролын хэлтэс нь тухайн нутаг дэвсгэрийн цэцэрлэг, сургуульд удирдлагын болон мэргэжлийн туслалцаа үзүүлэх, боловсролын байгууллагын удирдах ажилтан, багш, иргэнд боловсрол, мэргэжил эзэмших, мэргэшлээ дээшлүүлэх судалгаа, шинжилгээ эрхлэхэд нь туслах чиг үүргийг хэрэгжүүлнэ.



Батлагдсан бүтэц зохион байгуулалтын схемд Сургалт арга зүйн хэлтэст СӨБ нь харьяалагдаж байгаа бөгөөд ажлын байрны тодорхойлолтод хэлтсийн даргын болон СӨБ хариуцсан мэргэжилтний чиг үүргийг байгууллагын хуулиар тодорхойлсон чиг үүрэгтэй уялдуулан оновчтой бүрэн тодорхойлсон байна. Үүнд:

Хүснэгт № 5: Чиг үүргийн хоорондын уялдаа холбоо

Сургалт арга зүйн хэлтсийн даргын чиг үүрэг:	Сургуулийн өмнөх боловсрол хариуцсан мэргэжилтний чиг үүрэг
Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, Бага дунд боловсролын тухай хууль, бусад хууль тогтоомжийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг мэргэжил арга зүйн удирдлага, мэдээллээр хангах...	Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, Боловсролын тухай багц хууль, СӨБ-ийн тухай хууль бусад хууль тогтоомжийг аймгийн СӨБ-ийн байгууллагын хүрээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах холбогдох байгууллагуудад зөвлөгөө өгөх, мэргэжлийн дэмжлэг үзүүлэх, мэдээллээр хангах, цэцэрлэгт удирдлагын болон мэргэжлийн туслалцаа үзүүлэх, удирдах ажилтан багш, туслах багшийн мэргэжлийг дээшлүүлэх, хамтран ажиллах, судалгаа шинжилгээний ажил эрхлэхэд нь туслах

¹⁰ Боловсролын тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасны дагуу аймгийн ИТХ нь боловсролын асуудлаар тухайн шатны ба доод шатны Засаг даргын тайлан хэлэлцэж, чиглэл өгөх, орон нутгийн өмчийн боловсролын байгууллагыг хөгжүүлэх төлөвлөгөө батлах, биелэлтэд хяналт тавьж, аймгийн эдийн Засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, түүний биелэлтийг жил бүр хурлын хуралдаанаар хэлэлцэн баталж үнэлэлт дүгнэлт өгч иржээ.

Аймгийн Засаг дарга нь жил бүр БСШУ-ны сайдтай хамтран ажиллах гэрээг байгуулан ажиллаж, Боловсролын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулж байна.

Чиг үүргийн хүрээнд аймгийн ЗДТГ-ын нийгмийн бодлогын хэлтэст боловсролын асуудал хариуцсан мэргэжилтэн ажиллаж байгаа бөгөөд тус мэргэжилтний чиг үүргийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд: Аймгийн хэмжээнд боловсролын салбарын хууль тогтоомжийг орон нутагт хэрэгжүүлэх, бодлого хөтөлбөр, төсөл боловсруулах, төлөвлөх, зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх, хянах, үнэлэх, үйл ажиллагааг мэргэжил, арга зүй удирдлагаар хангахад оршино.

Орон нутгийн түвшинд боловсролын бодлого хариуцаж буй бодлогын хэлтэс, түүний мэргэжилтний ажлын чиг үүргийг оновчтой тодорхойлсон байна.

Мөн СӨБ-ын байгууллагын удирдлагын чиг үүргийг Боловсролын тухай хуульд заасан үүргийг хэрэгжүүлэхүйц байхаар боловсруулан түүнийг дагаж мөрдүүлж ажиллаж байна.



Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд “Хүүхдийн цэцэрлэг” нь хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны хүүхдийг асрах, хамгаалах, хөгжүүлэх цогц үйл ажиллагаа эрхлэх сургалтын байгууллага байхаар тодорхойлсны дагуу бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлж байна.

А.2.2. СӨБ-ийн байгууллагуудын санхүүжилтийн тогтолцоо нь Төсвийн тухай хуульд заасан зарчмын дагуу явагдаж байгаа ба чиг үүргийг хэрэгжүүлэх бүтцийг оновчтой зохион байгуулсан байна.

11 Боловсролын тухай хуулийн 40⁶ дүгээр зүйл, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 15⁷ дугаар зүйлд заасны дагуу санхүүжилтийн тогтолцоо хэрэгжиж байна. Аймгийн хэмжээнд боловсролын салбарын төсвийн мэргэжилтэн нь аймгийн ЗДТГ-ын Санхүү, Төрийн сангийн хэлтэст харьяалагдаж “Аймгийн боловсрол соёлын төсвийн төлөвлөлт, бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалт, төсөв санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих, эдийн засгийн судалгаа шинжилгээ хийх” гэсэн чиг үүргийн хүрээнд ажиллаж байна.

Тус мэргэжилтэн нь цэцэрлэгүүдийн нягтлан бодогчоос төсвийн төслийг хянан хүлээн авч нэгтгэн Сангийн яаманд хянуулж аймгийн ИТХ-ын хуралдаанаар төсвийг батлуулан төсвийн шууд захирагчийн саналыг үндэслэн хуваарилалтыг төсөв захирагч тус бүрээр хийж, зарцуулалтад хяналт тавьж ажиллажээ.

13 Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлд аймгийн Засаг дарга Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэхээр заасан бөгөөд энэхүү чиг үүрэгт СӨБ багтсан бөгөөд тус хуулийн 56,1,3⁸-т заасны дагуу улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжигдэж байна.

Аймгийн Засаг дарга Төсвийн тухайн хуулийн 61.3 заасны дагуу орон нутгийн санхүүжилтийн хуваарилалт хийх саналыг боловсруулан аймгийн ИТХ-д өргөн барьж байгаа бөгөөд тус саналд үндэслэн аймгийн ИТХ нь тус хуулийн 61.4-т заасны дагуу орон нутгийн төсвийн бүрэлдэхүүн хэсэг болгон баталж ирсэн байна.

Орон нутагт СӨБ олгох үйлчилгээ үзүүлэх санхүүжилтийн үйл явц нь хуулиар тодорхойлсон чиг үүргийн дагуу явагдаж байна.

**БҮЛЭГ 2. БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТ ҮР
НӨЛӨӨТЭЙ, ҮР ДҮНТЭЙ
БАЙНА УУ?**

**ОРОН ТООНЫ БОЛОН НЭГ ХҮҮХДЭД НОГДОХ ХУВЬСАХ ЗАРДЛЫН
ЗОХИСТОЙ БАЙДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙЖ ТӨСВИЙН ҮР АШГИЙГ
НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ БАЙНА.**

⁸ Засгийн газрын хэрэгжүүлэх зарим чиг үүргийг орон нутаг төлөөлөн хэрэгжүүлэхэд зориулж улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлэг.



Б.1 СӨБ-д олгох үйлчилгээг бодитой төлөвлөж төрөөс СӨБ-ийн хамрагдалтыг сайжруулах бодлого барьж ажилласнаар хамрагдалт хүртээмж сүүлийн 3 жилд өссөн байна.

Б.1.1. Шинээр баригдсан цэцэрлэгүүдийн анги дүүргэлт хангалттай байгаагаас үзэхэд хүн амын нягтрал, өрхийн тоонд уялдуулан төлөвлөжээ.

14 2018 оны жилийн эцсийн байдлаар улсын төсвийн нийт 35 цэцэрлэг, 37 барилга байгууламжид үйл ажиллагаа явуулж байна.

Барилгын тухай 46.1.14⁹ -д заасны дагуу аймгийн МХГ-аас дээрх барилгуудын ашиглалтын байдалд төлөв байдлын судалгаа хийж үнэлэлт дүгнэлт өгсөн байна.

Барилгын ашиглалтын байдлын судалгаагаар нийт 36 барилгын 42 хувь буюу 15 барилга нь 1971-1990 онд, 5 хувь буюу 2 барилга нь 1991-2000 онд, 53 хувь буюу 19 барилга нь 2001-2018 онд, 1 барилга нь 2019 онд шинээр ашиглалтад орсон байна.

Аудитад хамрагдсан 2016-2018 онуудад улсын төсвийн хөрөнгө оруулалт, концессын гэрээ, хандиваар нийт 450 хүүхдийн хүчин чадалтай 9 цэцэрлэг шинээр ашиглалтад орсон байна.

Хүснэгт № 6. Шинээр баригдсан цэцэрлэгт хамрагдсан хүүхдийн судалгаа

Цэцэрлэг	бүлэг	Өмнөх	Төлөвлөсөн	Нэмэгдсэн	СӨБ-д хамрагдвал зохих	Гүйцэтгэлээр	Өрхийн тоо	Хүн амын тоо
Шаргалжуут 8-р цэцэрлэг	4	50	75	25	152	121	401	1356
13-р цэцэрлэг	4	0	100	100	190	127	609	1891
6-р цэцэрлэг	4	0	100	100	202	127	1141	4442
1-р цэцэрлэг	2	100	100	0	192	235	553	1623
Баян-Ойт сургууль цэцэрлэгийн цогцолбор	3	50	100	50				
15-р цэцэрлэг	4	0	100	100	120	109	389	2371
Богд сумын цэцэрлэг	4	0	50	50	298	62	892	3097
Өлзийт сумын цэцэрлэг	4	75	100	25	339	114	1116	3802
Шинэжинст сумын цэцэрлэг	4	100	100	0	262	80	746	2428
Нийт	33	375	825	450	1755	975	5847	21010

⁹ барилга байгууламжийн ашиглалтын хугацааны 15 жил тутамд барилга байгууламжийн төлөв байдалд барилгын улсын хяналтын асуудал эрхэлсэн байгууллагаар дүгнэлт гаргуулж, холбогдох арга хэмжээг авах.



Шинээр ашиглалтад орсон цэцэрлэгүүдийн хувьд 450 хүүхэд хүлээн авах хүчин чадал нэмэгдэж нийт 825 хүүхэд авах хүчин чадалтай болсон бөгөөд 2018 оны хувьд гүйцэтгэлээр 975 хүүхэд цэцэрлэгт хамрагдаж 525 хүүхэд нэмж хамрагдсан байна. Шинээр баригдсан цэцэрлэгүүдийн анги дүүргэлт хангалттай байгаагаас үзэхэд хүн амын нягтрал, өрхийн тоонд уялдуулан төлөвлөсөн байна.

Аудитын илрүүлэлт:

Харин Өлзийт сумын цэцэрлэгийн хуучин барилгын насжилт дуусаагүй байхад шинээр цэцэрлэг барьсан ба Энэ талаар тайлбар авахад БСУГ-ын холбогдох мэргэжилтнээс тодруулахад “барилгын дам нуруу хотойсноос цэцэрлэгийн зориулалтаар ашиглах боломжгүй гэсэн дүгнэлт гаргасан” гэх боловч энэ нь баримтаар нотлогдоогүй болно. Одоогоор барилгыг сумын ерөнхий боловсролын сургуулийн албан бус боловсролын зориулалтаар ашиглаж байгаагаас үзэхэд тус цэцэрлэгийн хувьд барилгын насжилтыг харгалзан үзээгүйгээр төлөвлөсөн байна.

15 Баянхонгор аймгийн хэмжээнд 2019 оны байдлаар төрийн өмчит 35 цэцэрлэг нийт 3940 хүүхэд хүлээн авах хүчин чадалтайгаар үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд 2018 оны СӨБ-д хамрагдсан статистик мэдээгээр нийт 5396 хүүхэд цэцэрлэгийн үндсэн бүлгээр үйл ажиллагаа явуулж байгаагаас үзэхэд 36,9 хувиар илүү ачаалалтай үйл ажиллагаа явуулж байна.

Дээрх цэцэрлэгүүд нь бүрэн хүчин чадлаараа ажилласан бөгөөд зарим цэцэрлэгүүд анги танхимыг зориулалтын дагуу ашиглаагүй зөрчил илэрлээ. Тухайлбал:

Аудитын илрүүлэлт

- Эрдэнэцогт сумын цэцэрлэг нь анги танхимын зориулалтаар ашиглах 2 ангийг ашиглалгүй агуулах болгосон байгаа ба МХГ-ын байцаагчийн гаргасан төлөв байдлын судалгаанаас үзэхэд цаашид их засвар хийгээд ашиглах боломжтой гэж дүгнэлт гаргасан.
- Эрдэнэцогт сум нь 2018 онд аймгийн ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар 158.0 сая төгрөгийн өртөг бүхий багийн цэцэрлэг барьсан бөгөөд халаалтын асуудлыг цахилгаанаар шийдсэн, тус баг нь цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй, цэцэрлэгийн орон тооны төсвийн асуудлыг шийдвэрлээгүй байна.
- Баянцагаан, Баацагаан сумын цэцэрлэг нь дуу хөгжим, биеийн тамирын зориулалтаар ашиглах танхимыг цэцэрлэгт хамрагдаж буй хүүхдийн ачаалалтай байдлаас бүлэг болгон үйл ажиллагаа явуулж байгаа.

16 Аудитаар 2016-2018 онд шинээр ашиглалтад орсон нийт 9 цэцэрлэгт батлагдсан стандартын дагуу орчны үнэлгээг хийхэд цэцэрлэгийн зарим хэсэг нь сургалтын орчны шаардлага хангаагүй байгаа нь Боловсролын тухай хуулийн 42.2.1¹⁰ дэх заалтыг зөрчиж байна.

Хүснэгт № 7. Шинээр баригдсан цэцэрлэгийн сургалтын орчны үнэлгээ

¹⁰ 2.1.Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш, ажилтан, суралцагчийн хөдөлмөрийн онцлогт тохирсон, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна.



№	Цэцэрлэгийн нэр	СӨБ-ын байгууллагын сургалтын орчин 6558:2015 бүрэн хангасан эсэх
1	13-р цэцэрлэг	Гадаад орчны14 шалгуураас 5, барилга байгууламжийн 40 шалгуураас 8 , аюулгүй байдлын 14 шалгуураас 1 тус тус хангаагүй байна
2	6-р цэцэрлэг	Гадаад орчны14 шалгуураас 2, барилга байгууламжийн 40 шалгуураас 12 , аюулгүй байдлын 14 шалгуураас 3 тус тус хангаагүй байна
3	1-р цэцэрлэг	Гадаад орчны14 шалгуураас 8, барилга байгууламжийн 40 шалгуураас 8 , аюулгүй байдлын 14 шалгуураас 2 тус тус хангаагүй байна
4	Богд сумын цэцэрлэг	Гадаад орчны14 шалгуураас 8, барилга байгууламжийн 40 шалгуураас 6 , аюулгүй байдлын 14 шалгуураас 5тус тус хангаагүй байна
5	15-р цэцэрлэг	Гадаад орчны14 шалгуураас 7, барилга байгууламжийн 40 шалгуураас 5 , аюулгүй байдлын 14 шалгуураас 2 тус тус хангаагүй байна
6	Шаргалжуут 8-р цэцэрлэг	Гадаад орчны14 шалгуураас 5, барилга байгууламжийн 40 шалгуураас 8 , аюулгүй байдлын 14 шалгуураас 1 тус тус хангаагүй байна
7	Шинэжинст сумын цэцэрлэг	Гадаад орчны14 шалгуураас 4, барилга байгууламжийн 40 шалгуураас 10 , сургалтын хэрэглэгдэхүүний 7 шалгуураас 1, аюулгүй байдлын 14 шалгуураас 3 тус тус хангаагүй байна
8	Өлзийт сумын цэцэрлэг	Гадаад орчны14 шалгуураас 6, барилга байгууламжийн 40 шалгуураас 5 , аюулгүй байдлын 14 шалгуураас 4 тус тус хангаагүй байна
9	Баян-Ойт сургууль цэцэрлэгийн цогцолбор	Гадаад орчны14 шалгуураас 9, барилга байгууламжийн 40 шалгуураас 14 , аюулгүй байдлын 14 шалгуураас 2 тус тус хангаагүй байна

Дээрх зөрчлүүдээс дурдвал:

Шинэжинст сумын цэцэрлэг хүүхдийн хоолны хэрэглэлийг бүлэгт байрлуулсан, Өлзийт сумын цэцэрлэг нь Хэвтээ элементтэй шатны хөндлөвчийг хүүхэд гишгэж, авирах, унахаас сэргийлж хашилт хийж хамгаалаагүй, Баян-Ойт цогцолбор, 6-р цэцэрлэгүүд нь галт тогооны агааржуулалтын систем нь хэвийн ажиллагаагүй гэх мэт шаардлага хангаагүй зөрчлүүд илэрч зөрчлийг арилгах албан шаардлагыг холбогдох цэцэрлэгийн эрхлэгч нарт хүргүүлэв.

Б.1.2. 2016-2018 онд Баянхонгор суманд шинээр баригдаж ашиглалтад орсон цэцэрлэгүүд нь хэрэгцээ шаардлагын дагуу аймгийн ерөнхий төлөвлөгөөнд бүрэн туссан байна.

17 2016-2018 онд шинээр баригдсан 9 цэцэрлэг баригдсаны 5 цэцэрлэг нь аймгийн төвд байршилтай, 4 цэцэрлэг нь сумдад баригдсан ба сумдын хувьд Ерөнхий төлөвлөгөөг батлаагүй харин тухайн жилийн сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд орж батлагдсан байна.

Харин Баянхонгор аймгийн төвийн ерөнхий төлөвлөгөөг “Сүсон инженеринг” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн ба тухайн төлөвлөгөөнд Баян-Ойт сургууль цэцэрлэгийн цогцолбор, 1, 6, 13-р цэцэрлэгүүд нь сургууль цэцэрлэгийн бүсэд төлөвлөгдсөн ба харин 15-р цэцэрлэг нь цэцэрлэг байхаар төлөвлөгдөөгүй байна.

Тус 15-р цэцэрлэг нь орон нутгийн өмчит “Чандмань-Баянхонгор” ХХК-ийн конторын барилгыг шинээр баригдахаар төлөвлөж, ажилчдын хүүхдийг хамруулах зорилгоор анх аймгийн ОНХС-гаас санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр шийдвэрлэж байсан ба барилга баригдах явцад хүчин чадлыг нэмэгдүүлэн УТХО-аар 100 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэг болгон өөрчлөн, тус барилгыг барьж



ашиглалтад хүлээн авсан байна. Тус цэцэрлэг нь гадна орчны шаардлага хангаагүй, гадна талбайд эзэмшил байхгүйгээс тоглоомын талбай байхгүй байна

18 Баянхонгор аймагт “Хонгор 1000” орон сууцны хороолол, “Шинэ суурьшлын бүс”, “Залуус” зэрэг хэсэгчилсэн орон сууцны хороолол баригдахаар төлөвлөгөө гарсан ба “Хонгор 1000” хорооллын хүрээнд 150 хүүхдийн цэцэрлэг 2014 онд ашиглалтад орсон байна. Харин цаашид “Шинэ суурьшлын бүс”, “Залуус” хороолол нь хэрэгжиж эхлэх шатандаа явагдаж байгаа бөгөөд тус хорооллуудад цэцэрлэг барихаар төлөвлөсөн байна.

Б.1.3. СӨБ-д хамрадаж буй хүүхдийн тоо нь сүүлийн 3 жилд өсөлттэй байгаа нь төрөөс СӨБ-ийн хамрагдалтыг сайжруулах бодлого барьж ажиллаж байгаа нь нөлөөлж байна.

19 Аймгийн хэмжээнд 2018 онд төрийн өмчийн 35, хувийн өмчийн 7 нийт 42 цэцэрлэгийн 248 бүлэгт 7836 хүүхэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшиж байгаа бөгөөд хамрагдсан нийт хүүхдийн 4204 хүүхэд сумдын цэцэрлэгт, 430 хувийн цэцэрлэгт сурч байна.


Хүснэгт № 8. Аймгийн хэмжээний СӨБ-д хамрагдсан хүүхдийн судалгаа

Цэцэрлэгийн нэр	2016 он			2017 он			2018 он		
	Хамрагд-вал зохих	Хамрагд-сан	хувь	Хамрагд-вал зохих	Хамрагд-сан	хувь	Хамрагд-вал зохих	Хамрагд-сан	хувь
Баянхонгор сум	3254	3270	100.5	3287	3582	108.1	3346	3591	107.3
Баацагаан	306	251	82.0	308	239	77.6	286	232	81.1
Баянбулаг	159	146	91.8	163	154	94.5	161	151	93.8
Баянговь	269	169	62.8	261	180	69.0	263	165	62.7
Баянлиг	369	298	80.8	393	307	78.1	376	320	85.1
Баян-Овоо	256	140	54.7	243	143	58.8	234	133	56.8
Баян-Өндөр	252	204	81.0	241	200	83.0	248	200	80.6
Баянцагаан	347	338	97.4	356	344	96.6	355	335	94.4
Богд	301	215	71.4	306	292	95.4	287	277	96.5
Бөмбөгөр	331	270	81.6	369	305	82.7	387	320	82.7
Бууцагаан	351	332	81.2	336	326	83.3	297	290	83.8
Галуут	354	249	70.3	365	251	68.8	350	263	75.1
Гурванбулаг	158	176	111.4	184	179	97.3	208	198	95.2
Жаргалант	234	175	74.8	258	180	69.8	265	205	77.4
Жинст	231	140	60.6	223	156	70.0	218	144	66.1
Заг	181	170	93.9	196	170	86.7	174	164	94.3
Өлзийт	340	210	61.8	335	218	65.1	343	180	52.5
Хүрээмарал	175	152	86.9	174	165	94.8	163	133	81.6
Шинэжинст	264	195	73.9	266	203	76.3	257	239	93.0
Эрдэнэцогт	418	323	77.3	392	296	75.5	362	296	81.8
Нийт дүн	8550	7423	86.3	8656	7890	90.3	8580	7836	90.9

СӨБ-д хамрагдалтыг сумдаар авч үзэхэд Баян-Овоо, Өлзийт, Жинст сумдын хамрагдалт аймгийн дунджаас хэт доогуур байгаа нь аймгийн төвтэй газарзүйн байршлын хувьд ойр байгаатай холбоотой байна.



График № 1. СӨБ-д хамрагдаж байгаа хамрагдалтын хэлбэр



СӨБ-д хамрагдаж буй хүүхдийн тоо нь сүүлийн 3 жилд өсөлттэй байгаа нь төрөөс СӨБ-ийн хамрагдалтыг сайжруулах бодлого барьж ажиллаж байгаа нь нөлөөлж байна.

20 Баянхонгор аймгийн хэмжээнд хувийн өмчийн 7 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж 2016 онд 320.0 сая, 2017 онд 317.8 сая, 2018 онд 364.7 сая төгрөгийн санхүүжилт батлагсныг аймгийн ЗДТГ-ын СТСХ нь батлагдсан хүүхдийн тоогоор санхүүжилтийг сар бүр хуваарийн дагуу олгож байна.

Хүснэгт № 9. Хувийн өмчийн цэцэрлэгт олгосон санхүүжилтийн судалгаа

№	Цэцэрлэгийн нэр	Цэцэрлэгийн хүчин чадал	Санхүүжих дундаж хүүхэд			Олгосон санхүүжилт		
			2016 он	2017 он	2018 он	2016 он	2017 он	2018 он
1	Эко	120	134	85	85	95.1	69.0	69.0
2	Гэгээхэн	100	134	90	90	95.0	73.1	73.8
3	Эрхэт тамч	75		10	25	0.0	7.5	20.5
4	Тэргэл	150	134	100	127	95.1	81.2	103.4
5	Тэмүүлэл	25	50	35	30	34.8	28.4	23.8
6	Баянцэцүүхэй	50			30	0.0	0.0	24.9
Дүн			452	320	387	0.0	259.4	315.3
7	Хөгжлийн бэрхшээлтэй	20		24	20	0.0	58.5	49.5
Дүн			452	344	407	320.0	317.8	364.7

Аудитаар хувийн өмчийн цэцэрлэгүүдийн санхүүжилтийг хүүхдийн хувьсах зардлаар сар бүр олгож байгааг шалгахад БСУГ хүүхэд өдрийн гүйцэтгэлд хяналт тавьж баталгаажуулаагүй байхад Төрийн сан хуваарийн дагуу санхүүжилтийг олгож байгаа нь Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолоор батлагдсан “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативаар



санхүүжүүлэх аргачлал"-ын 3.12¹¹-т заасан гэсэн заалтын бүрэн хэрэгжүүлээгүйгээс хувийн өмчийн цэцэрлэгүүдэд 17058,3 мянган төгрөгийн санхүүжилтийг илүү олгосон зөрчил илэрч төлбөрийн акт тогтоов.

Аудитын илрүүлэлт:

- "Гэгээхэн гэрэл" цэцэрлэг нь хүүхдийн гүйцэтгэлээс 4,1 сая төгрөгийн илүү санхүүжилт авсан.
- "Тэргэл гэрэл" цэцэрлэг нь хүүхдийн гүйцэтгэлээс 4,1 сая төгрөгийн илүү санхүүжилт авсан
- "Баянцэцүүхэй" цэцэрлэг нь хүүхдийн гүйцэтгэлээс 1,6 сая төгрөгийн илүү санхүүжилт авсан
- "Эко" цэцэрлэг нь хүүхдийн гүйцэтгэлээс 4,1 сая төгрөгийн илүү санхүүжилт авсан
- "Тэмүүлэл" цэцэрлэг нь хүүхдийн гүйцэтгэлээс 2,4 сая төгрөгийн илүү санхүүжилт авсан
- "Эрхт тамч" цэцэрлэг нь хүүхдийн гүйцэтгэлээс 0,8 сая төгрөгийн илүү санхүүжилт авсан

Иймд цаашид хувийн өмчийн цэцэрлэгүүдийн санхүүжилтийг олгохдоо дээрх журмыг мөрдөн хүүхэд өдрийн гүйцэтгэлийн баталгаажуулж, холбогдох нэхэмжлэлийг үндэслэн санхүүжилтийг гүйцэтгэлээр нь олгож байх зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлэв.

Б.1.4 СӨБ-ийг цөм хөтөлбөрийн дагуу хөдөлгөөн эрүүл мэнд, зан чанар, хэл яриа, байгаль орчин, математик, дүрслэх урлаг зэрэг чиглэлээр чадвар эзэмшүүлж байна.

21 Аймгийн БСУГ нь насан туршийн боловсролын суурь чадварыг бүрэн эзэмшсэн эсэхийг цэцэрлэгүүдийн бэлтгэл бүлгийн стандарт хангалтын түвшинг нэгтгэн гаргаж ахиц, амжилт чанарыг хүүхдийн хөгжлийн дундаж үзүүлэлтийн нэгтгэлийг дүгнэж байна. Тухайлбал:

График № 2. Бэлтгэл бүлгийн хүүхдийн 2017 оны стандарт хангалтын үнэлгээ



БСУГ-аас 2017 онд бэлтгэл бүлгийн нийт 42 бүлгийг 874 хүүхэд төгссөн ба бүлгийн стандарт хангалтын түвшинг гаргахад амжилт 83,6 хувь, чанар 58.9 хувьтай үнэлэгдсэн байна.

¹¹ “Сургалтын нормативт зардлын санхүүжилтийг аймгийн боловсролын газар сар бүр хүүхэд өдрөөр хянаж, төсвийн санхүүжилтийн сар, улиралын хуваарьт батлагдсаны дагуу сар тутам олгоно”



Мөн 2018 онд ахицын үнэлгээгээр нийт төрийн өмчийн 19 цэцэрлэгийг түүвэрлэн авч үзсэн байна.

Хүснэгт № 10 . Түүвэрт хамрагдсан цэцэрлэгийн ахицын үнэлгээ

Д/Д	Цэцэрлэгийн нэр	Нийт гүйцэтгэлийн дундаж		Ахиц	№	Цэцэрлэгийн нэр	Нийт гүйцэтгэлийн дундаж		Ахиц
		Намар	Хавар				Намар	Хавар	
1	1-р цэцэрлэг	3.2	4.3	3.7	11	Гурванбулаг	2.1	3.6	2.9
2	2-р цэцэрлэг	2.0	3.3	1.6	12	12-р цэцэрлэг	2.2	3.9	3.0
3	3-р цэцэрлэг	2.0	3.6	2.8	13	13-р цэцэрлэг	2.2	3.7	3.0
4	4-р цэцэрлэг	1.9	3.5	2.7	14	Өлзийт	2.1	3.9	3.0
5	5-р цэцэрлэг	2.0	3.5	2.8	15	Баянлиг	2.2	3.9	3.1
6	6-р цэцэрлэг	2.2	3.5	2.8	16	Баянговь	1.9	4.1	3.0
7	7-р цэцэрлэг	2.5	3.2	2.8	17	Баянцагаан	2.0	4.2	3.1
8	Шаргалжуут	1.9	3.3	2.6	18	Бууцагаан	1.9	4.1	3.0
9	Заг	1.6	3.2	2.4	19	Бөмбөгөр	2.2	3.6	2.9
10	Жаргалант	2.1	3.5	2.8		Нийт	2.1	3.7	2.9

Аймгийн БСУГ нь аудитад хамрагдсан онуудаас цэцэрлэгүүдийн бэлтгэл бүлгийн стандарт хангалтын түвшинг тодорхойлсон мэдээлэл 2017 оноос бусад онд байхгүй, ахиц амжилтын матриц нь 2018 оноос өөр онуудад байхгүй байгаагаас он тус бүрээр харьцуулах боломжгүй байлаа.

Иймд бүлэг төгсөлтийн стандарт хангалтын түвшин, ахиц амжилтын матрицыг аймгийн СӨБ олгож буй цэцэрлэг бүрээр нэгтгэн бүрэн гаргаж өмнөх оны суурь түвшинтэй харьцуулж, дүн шинжилгээ хийж цаашид шийдвэр гаргахад мэдээллээр хангаж ажиллахыг аймгийн БСУГ-т зөвлөв.

22 СӨБ олгож буй төрийн өмчийн цэцэрлэгийн стандарт хангалтын түвшин, ахиц амжилтыг он тус бүрээр бүрэн гаргаагүй, хувийн өмчийн цэцэрлэгүүдийг огт гаргаагүй байгаа тул хувийн болон төрийн өмчийн цэцэрлэгт сургалтын чанарын түвшин хэрхэн байгаа талаар харьцуулалт хийх боломжгүй байгаа бөгөөд цаашид гаргаж, төрийн өмчийн цэцэрлэгийн түвшинтэй харьцуулалт хийж байх шаардлагатай байна.

23 СӨБ олгож буй цэцэрлэг тус бүрээр өөрийн онцлогт тулгуурлан өөрийн цэцэрлэгийн баримтлах үзэл баримтлалыг боловсруулж байгаа бөгөөд энэхүү баримт бичигтээ бүлгийн өдрийн дэглэмийг боловсруулан бүлэг тус бүрээр баталж байна.

Өдрийн дэглэмд дүн шинжилгээ хийж үзэхэд багш нар 8:30-18:00 цаг хүртэл тасралтгүй хүүхэдтэй ажиллаж байгаа бөгөөд баримт бичиг боловсруулах цагийг тусгайлан зааж өгөөгүй байна.



Б.2. Хөдөө сумдад мэргэжлийн боловсон хүчний хүрэлцээ хангалтгүй дутмаг байгаагаас СӨБ багшид тавих шаардлагыг хангаагүй, мэргэжлийн бус багш ажиллуулж байна.

Б.2.1. Мэргэжлийн боловсон хүчний хүрэлцээ хангалтгүй дутмаг байгаагаас өндөр насны тэтгэвэрт гарсан, мэргэжлийн бус багшийг ажиллуулсан байна.


24 2018-2019 оны хичээлийн жилд аймгийн хэмжээнд 794 багш, ажиллагчид ажиллаж байгаагаас 228 буюу 28.7 хувийг үндсэн багш эзэлж байна. Өмнөх оныхтой харьцуулахад цэцэрлэгт ажиллаж буй багш, ажиллагчид 6-аар буюу 0.7 хувиар нэмэгдсэн ба Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад ажиллаж байгаа үндсэн багш өмнөх жилээс 2.6 хувиар өсч, мэргэжлийн багшийн хангалт 96.5 хувь болсон нь өмнөх оноос 0.5 пунктээр өссөн үзүүлэлтэй байна.

Хүснэгт №11 Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад ажиллаж байгаа багш, ажиллагчид

Хичээлийн жил	Үндсэн багш	Үүнээс					туслах багш	бусад ажиллагчид
		бүлгийн	дуу хөгжим	биеийн тамир	ээлжийн	явуулын		
2016-2017	206	170	19		12	5	177	312
2017-2018	222	180	22		13	7	191	329
2018-2019	228	183	24	1	13	7	192	374

Аймгийн хэмжээнд бага насны хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх сургалтыг үндсэн, хувилбарт гэсэн хэлбэрээр эзэмшүүлж хамран сургалтын хувь 0.6 пунктээр өссөн үзүүлэлтэй байна.

График № 3 Нэг багшид ногдох хүүхдийн тоо, хамран сургалтын бохир жин 2016-2018 он



25 Боловсролын тухай хуулийн 43.1.4, 43.1.7 дахь заалтад тусгасны дагуу 2016-2018 онд 35 багш ажилтнуудад 291,5 сая төгрөгийн Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж, 116 багш ажилтнуудад 550,3 сая төгрөгийн Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийг олгож, багш ажилчдын ажлын үр дүнг улирал бүр дүгнэж 10-60% хүртэлх хэмжээгээр тооцож үр дүнгийн урамшууллыг батлагдсан төсөвт багтааж олгож иржээ. Хүснэгтээр харуулбал:



Хүснэгт: №12 2016-2018 онд олгосон мөнгөн тэтгэмж /сая.төг/

Үзүүлэлт	2016 он		2017 он		2018 он	
	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүн тоо	Мөнгөн дүн	Хүн тоо	Мөнгөн дүн
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22	175.6	9	70.0	4	45.8
Хөдсө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	23	60.7	67	230.6	84	259.0
Дүн	45	236.4	76	300.6	88	304.9

Мөн Засгийн газрын 2018 оны 264-р тогтоолоор багшийн үндсэн цалин дундажаар 631,5 мянган төгрөг болж 69,2 мянган төгрөгөөр буюу 12,3 хувиар, туслах багшийн үндсэн цалин 470,8 мянган төгрөг болж 34,8 мянган төгрөгөөр буюу 8 хувиар тус тус нэмэгдснийг тогтоолын дагуу тухай бүрт нь олгож байна.

26 Аймгийн хэмжээнд СӨБ-д үндсэн багшаар 228 багш ажиллаж байгаагаас дуу хөгжмийн багш- 24, биеийн тамирын багш -1, арга зүйч – 13 ажиллаж байна.

Мэргэжлийн боловсон хүчний хүрэлцээ хангалтгүй дутмаг байгаагаас тэтгэвэрт гарсан, бага ангийн багшийн мэргэжилтэй 12 багшийг ажиллуулсан байна.

Тухайлбал:

- Баянлиг сум 2016-2018 онд тэтгэвэрт гарсан багш ажиллуулсан.
- Баянговь сум үндсэн бүлгийн багшаар бага ангийн 2 багш ажиллуулсан.
- Бууцаган сум 2016 онд бага ангийн багш мэргэжилтэй 1 багш, хувилбар сургалтын багшаар бага ангийн багш мэргэжилтэй 2 багш ажиллуулсан.
- Баянбүрдний бага цэцэрлэг 2016-2018 оноос бүлгийн багшаар эчнээ сургалтад хамрагдаж буй мэргэжилгүй багш ажиллуулсан.
- Бөмбөгөр сум 2016-2018 онд үндсэн бүлгийн багшаар мэргэжилгүй 1 багш ажиллуулсан.
- Өлзийт сум дуу хөгжмийн багшаар багшлах эрхгүй дипломын боловсролтой 1 багшаар ажиллуулсан.
- Баянхонгор сумын 1,5,6,7,10-р цэцэрлэгүүд мэргэжлийн бус дуу хөгжмийн багш ажиллуулсан.

Б.2.2. Сургуулийн өмнөх боловсролын тухай 12.1 -т заасныг зөрчиж СӨБ багшид тавих шаардлагыг хангаагүй мэргэжлийн бус багшийг ажиллуулсан байна.

27 Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 10.1¹²-т цэцэрлэгийн удирдлагад тавигдах шаардлагыг СӨБ-ийн чиглэлээр их дээд сургууль төгссөн, ажлын туршлагатай байхаар заасан байна.

Аудитаар хуульд заасан шаардлага, ажлын байрны тодорхойлолтод заасан шаардлагыг удирдлагын хувийн хэрэгтэй тулган шалгахад нийт төрийн өмчийн 36 цэцэрлэгийн эрхлэгчээс 14, 15, Бууцаган сумын Баянбүрдний багийн цэцэрлэгийн

¹² Төрийн болон төрийн бус өмчийн цэцэрлэгийг сургуулийн өмнөх боловсролын багш бэлтгэдэг их, дээд сургууль, коллеж төгссөн, ажлын туршлагатай эрхлэгч удирдах бөгөөд түүнийг үүсгэн байгуулагч томилно.
ГАГ-2019/03/-ГА



эрхлэгч нар СӨБ-ийн чиглэлээр бус ЕБС-ийн чиглэлээр их дээд сургууль төгссөн байгаа нь дээр дурдсан хуулийн заалтыг хангахгүй байна.

Дээрх 3 эрхлэгч нь түр хугацаагаар томилогдсон байсан бөгөөд 2019 онд мэргэжил хөрвүүлэх сургалтаар СӨБ-ын чиглэлээр төгсөж бакалаврын диплом авсан байна.

28 Сургуулийн өмнөх боловсролын тухай 12.1¹³-т заасныг зөрчиж СӨБ багшид тавих шаардлагыг хангаагүй мэргэжилийн бус багшийг ажиллуулсан байна. Тухайлбал:

Аудитын илрүүлэлт:

- Баянговь сумын цэцэрлэг нь багшлах эрх аваагүй 1 багш, туслах багшийн мэргэшүүлэх сургалтад хамрагдаагүй 2 туслах багш ажиллуулсан
- Шинэжинст сум 2018-2019 хичээлийн жилд үндсэн бүлгийн багшаар мэргэжлийн бус 2 багш, хувилбарт сургалтын багшаар 1 багш, багшлах эрх аваагүй 2 багш ажиллуулсан.
- Баян-Өндөр сум 2016, 2017 онд цэцэрлэгийн эрхлэгч өөрийн төрсөн охиныг оюутан байхад нүүдлийн бүлгийн багшаар 2019 онд үндсэн бүлгийн багшаар ажиллуулсан.
- Галуут сумын цэцэрлэг үндсэн бүлгийн багшаар мэргэжлийн бус 2 багш, багшлах эрхгүй 1 багшаар ажиллуулсан.
- Эрдэнэцогт сумын цэцэрлэгийн эрхлэгчээр ажиллаж байсан мэргэжлийн бус багшийг томилож ажиллуулсан.
- Баацагаан сум 2018 онд үндсэн бүлгийн багшаар мэргэжлийн бус 1 багш ажиллуулсан.
- Бууцаган сум 2016 онд бага ангийн багш мэргэжилтэй 1 багш, 2018 онд багшлах эрхгүй 2 багш, хувилбар сургалтын багшаар бага ангийн багш мэргэжилтэй 2 багш ажиллуулсан.
- Баянбүрдний бага цэцэрлэг 2016-2018 оноос бүлгийн багшаар эчнээ сургалтад хамрагдаж буй мэргэжилгүй багш ажиллуулсан.
- Бөмбөгөр сум 2016-2018 онд үндсэн бүлгийн багшаар 1 багш,
- Өлзийт сум дуу хөгжмийн багшаар багшлах эрхгүй дипломын боловсролтой 1 багшаар ажиллуулсан.
- Баянхонгор сумын 6 цэцэрлэг багшлах эрхгүй 2 багш ажиллуусан.

Иймд дээрх зөрчлүүдийг арилгах албан шаардлагыг аймгийн БСУГ-т хүргүүлэв.

29 Баянхонгор аймгийн засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрт тусгагдсан “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулиудын багш нарын мэргэжил, авъяас, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх зорилгоор жил бүр шалгаруулалт явуулж, нийгмийн асуудлыг шийдвэрлэх тогтвор суурьшилтай ажиллуулах “**Сайн багш**” хөтөлбөр хүрээнд:

¹³ Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад сургуулийн өмнөх боловсролын чиглэлээр бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй багш ажиллана.



Япон улсын Кавасаки хотын Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах сургалт үйл ажиллагаанд оролцуулж нэг цэцэрлэгийн эрхлэгчид 3,0 сая төгрөгийн зардлын хөнгөлөлт үзүүлсэн байна.

Боловсрол соёл урлагийн газраас 2017-2018 онд СӨБ-ын мэргэшүүлэх сургалтыг 15 бүлэг сэдвээр давхардсан тоогоор 682 эрхлэгч багш ажилчдыг хамруулсан сургалтыг зохион байгуулсан байна.

График № 4 Мэргэшүүлэх сургалтын хамрагдалт



Аудитад хамрагдсан төрийн болон төрийн бус цэцэрлэгт ажиллаж буй багш, ажилчид нь Боловсролын тухай хуулийн 44.2-т заасны дагуу жилд 1-2 удаа эрүүл мэндийн шинжилгээ, үзлэгт тогтмол хамрагдахаар байхад аудитаар зарим багш, ажилчид үзлэгт бүрэн хамрагдаагүй зөрчил илэрлээ. Иймд Эрүүл мэндийн үзлэгт багш, туслах багш, ажилчдын бүрэн хамрагдаж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах зөвлөмжийг байгууллагын удирдлага болон аймгийн МХГ-т хүргүүлэв.

Б.3 СӨБ-ын үйл ажиллагаанд олгож байгаа зардлыг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Б.3.1. СӨБ-ын байгууллагуудын төсвийн орлогыг Засгийн газраас тогтоосон нэг хүүхдэд ногдох нормативыг баримталж төлөвлөсөн байна

30 Баянхонгор аймгийн төвд 2016 онд санхүүжих дундаж хүүхдээр тооцож 2016 онд 319,9 сая, 2017 онд 317,8 сая, 2018 онд 364,7 сая төгрөгийг олгохоор төлөвлөсөн байна. Төлөвлөлтийн тооцоог хийхдээ хувийн цэцэрлэгийн өмнөх оны гүйцэтгэл, хүчин чадалыг үндэслэн хүүхдийн дундаж тоог тухайн онд мөрдөгдөж байсан ЗГ-ын 2012 оны 94-р, 2016 оны 242-р тогтоолоор тогтоосон нэг хүүхдэд ногдох хувьсах зардлаар тооцон төлөвлөж байна.

31 Улсын цэцэрлэгт суралцаж байгаа хүүхдийн хоолны зардлыг төрөөс бүрэн хариуцаж байгаа бөгөөд эцэг эхчүүдээс төлбөр аваагүй байна.

32 Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж нормативыг Засгийн газрын 2012 оны 94-р тогтоол, 2017, 2018 оны төсвийг 2016 оны 242-р тогтоолоор тооцсон байна.

Сургуулийн өмнөх боловсролд 2016 онд санхүүжих хүүхдийн тоог 2015-2016 оны статистик мэдээгээр 4854 хүүхэд, 2017 онд 2016-2017 оны статистик мэдээгээр 5380 хүүхэд, 2018 онд 2017-2018 оны статистик мэдээгээр 5700 хүүхэд суралцахаар



тооцоход 2016 онд 3,817,9 сая, 2017 онд 4,824,3 сая, 2018 онд 5,124,0 сая төгрөгөөр санхүүжихээр тооцоо гарч байна.

Хүснэгт № 13. Батлагдсан төсвийг хувьсах зардалтай харьцуулсан судалгаа

№	Зардлын нэр	2016			2017			2018		
		Батлагдсан төсөв	нормативт зардал	Зөрүү	Батлагдсан төсөв	нормативт зардал	Зөрүү	Батлагдсан төсөв	нормативт зардал	Зөрүү
1	Цалин НДШ	4135.5	3428.1	707.3	4403.0	4342.4	60.6	4881.9	4590.4	291.4
2	Бусад хувьсах зардал	209.1	118.7	90.4	333.4	131.0	202.4	313.9	137.9	176.0
	Төрийн өмчийн цэцэрлэгийн дүн	4344.6	3546.8	797.7	4736.4	4473.4	263.0	5195.8	4728.4	467.4
1	Цалин НДШ	305.9	261.5	44.4	307.0	340.1	-33.1	352.5	383.4	-30.8
2	Бусад хувьсах зардал	14.0	9.6	4.4	10.8	10.8	0.0	12.2	12.2	0.0
	Төрийн бус өмчийн цэцэрлэгийн дүн	320.0	271.1	48.9	317.8	350.9	-33.1	364.7	395.6	-30.8
	Бүгд дүн	4664.5	3817.9	846.6	5054.3	4824.3	229.9	5560.5	5124.0	436.5

Энэ нь 2016 онд 846,6 сая, 2017 онд 229,9 сая, 2018 онд 436,5 сая төгрөгөөр нормативт зардлаас илүү төсвийг батласан байгаа нь Засгийн газрын тогтоолоор цалинг нэмэгдүүлж байгаа боловч түүнтэй уялдуулан нэг хүүхдийн хувьсах зардлыг шинэчлэн батлаагүй байгаатай холбоотой байна.

Аудитаар ижил бүлэгтэй цэцэрлэгүүдийн бүлэг болон орон тооны хоорондын хамаарлыг харьцуулан үзэхэд дараах харилцан адилгүй байна.

Хүснэгт № 14. Бүлгийн тоог орон тоотой харьцуулсан судалгаа

бүлгийн тоо	2016		2017		2018	
	цэцэрлэгийн тоо	орон тоо	цэцэрлэгийн тоо	орон тоо	цэцэрлэгийн тоо	орон тоо
1	1	3	1	3	1	3
2	2	9	1	9	2	9
3	6	10-19	4	11-19	6	11-19
4	9	13-20	12	13-21	12	13-18
5	2	17-18	4	15-17	4	15-17
6	9	19-27	5	19-25	4	24-26
7	2	22-29	3	21-28	4	19-28
8	1	30	3	30-33	3	30-33
	32		33		36	

Мөн СӨБ-ын байгууллагын БСШУСС, СС-ын 2018 оны А/817/287 тоот тушаалаар хүчингүй болсон ШУБС, СС-ын 1995 оны 227/199 тоот тушаалаар батлагдсан хүүхдийн цэцэрлэгийн захиргаа-үйлчилгээний ажилтны орон тооны үлгэрчилсэн нормативыг мөрдөж ажиллаагүй ирсэн байна. Тухайлбал:

Тус үлгэрчилсэн нормативаар бие даасан 8-аас дээш бүлэгтэй цэцэрлэгт 1 нягтлан бодогч, 6-аас дээш бүлэгтэй цэцэрлэгт арга зүйч ажиллахаар байхад аймгийн төвийн цэцэрлэгт бүлгийн тоог харгалзахгүй 1 нягтлан бодогч ажиллаж байхад сумдын ЕБС болон цэцэрлэгийг хавсарган



1 нягтлан бодогч ажиллаж байна. Мөн СӨБ-ийн байгууллагад цөм хөтөлбөр хэрэгжиж эхэлснээр аймгийн төвийн цэцэрлэгүүдэд арга зүйчийн орон тоо байх шаардлагатай болсон гэж аймгийн төвийн цэцэрлэгт орон тоо баталсан байна.

Гэтэл ШУБС, СС-ын 1995 оны 227/199 тоот тушаалыг БСШУСС, СС-ын 2018 оны А/817/287 тоот тушаалаар хүчингүй болгосон гэж legalinfo.mn сайтад байгаа боловч хүчийнгүй болгосон дээр тушаалыг нийтэд мэдээлээгүй, СӨБ-ын байгууллагуудад түгээгээгүй байна.

33 Нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын бусад хувьсах зардлын бүрэлдэхүүнд хичээл практикийн зардлыг оруулан баталж байгаа бөгөөд 2016 онд 47,5 хувь, 2017 онд 61,6 сая, 2018 онд 13,0 сая төгрөгөөр баталсан байна.

Мөн Баянхонгор аймгийн нийгэм эдийн засгийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд Монгол Улсын оюуны өмчийн газрын даргын 2016 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/10 тоот тушаалаар Улсын бүртгэлд бүртгэгдсэн “Хүүхдийн буддаг ном” төслийн санаачлагч иргэн Д.Эрдэнэмөнхийн “Мазаалай 12 жил” төсөлд Аймгийн Засаг даргын 2018 оны А/140 дүгээр захирамжаар 7.5 сая төгрөг шийдвэрлэн тус бүр 3000 нийт 6000 ширхэг номыг 41 цэцэрлэгт хүргүүлэн 4-5 насны хүүхдийн сургалтын үйл ажиллагаанд хэрэглэсэн байна.

3.2. СӨБ-ын байгууллага нь зардлыг зориулалтын дагуу ашигласан боловч төсвийн үр ашгийг сайжруулах, хөрөнгө оруулалтын бодлоготой уялдуулан зардлыг төлөвлөх шаардлагатай байна.

34 Баянхонгор аймгийн СӨБ-ийн байгууллагуудад 2016-2018 онуудад нийт 26571,1 сая төгрөгийн төсөв батлагдснаас 26557,5 сая төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр үйл ажиллагааны зардалд 26245,2 сая төгрөгийг зарцуулан зарцуулагүй үлдэгдэл 312.3 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт № 15 СӨБ-ын төсвийн гүйцэтгэлийн нэгтгэл

Он	сая төгрөг				
	Анхны батлагдсан төсөв	Тодотгосон төсөв	Санхүүжилт	Гүйцэтгэл	Төвлөрүүлэлт
2016	8156.8	8274.9	8261.4	8004.0	257.4
2017	8460.5	8884.2	8884.2	8879.1	5.1
2018	9494.9	9412.0	9411.9	9362.1	49.8
Дүн	26112.2	26571.1	26557.5	26245.2	312.3

Хүснэгтээс харахад 2016 онд 257.4 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн нь хүүхдийн хоолны зардлын хэмнэлт 110,6 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой зардал 30,9 сая, цалин хөлс, НДШ-ийн 120,5 сая, бусад зардлын 5,2 сая төгрөгийг төвлөрүүлжээ. Энэ нь тухайн онд НДШ-ийн зардал хэмнэгдсэн нь аймгийн ИТХ-ын хуралдааны тогтоолоор нормативт зардлаас цалингийн зардалд 254,3 сая



төгрөгийн зардлын зохицуулалт хийснээс оны эцэст төсвийг зарцуулаагүй буцаан төвлөрүүлснээр харагдаж байна.

Харин 2017 онд бусад бараа үйлчилгээний 5,1 сая, 2018 онд нийт 49,8 сая төгрөгийг төвлөрүүлсэн ба үүнээс цалин НДШ-ийн 17,5 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 9,3 сая, хүүхдийн хоолны зардлын 11,2 сая, урсгал шилжүүлгийн 5,1 сая бусад зардлын 6,7 сая төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг төвлөрүүлсэн байна.

2016-2018 онуудад СӨБ-ийн байгууллагууд батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Хүснэгт № 16 Зардлын гүйцэтгэл /эдийн засгийн ангилалаар/

Зардлын зүйл	2016 он			2017 он			2018 он		
	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Төвлөрүүлэлт	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Төвлөрүүлэлт	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Төвлөрүүлэлт
НИЙТ ЗАРЛАГА ДҮН	8,274.9	8,017.7	257.2	8,884.2	8,879.1	5.0	9,412.0	9,362.1	49.9
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,714.1	7,459.5	254.6	8,081.0	8,077.9	3.1	8,726.1	8,681.3	44.8
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	4535.8	4431.6	104.2	4,689.5	4,690.4	(0.9)	5,005.8	4,996.7	9.1
Ажил олгогчоос НДШ	500.0	483.6	16.3	524.7	523.2	1.5	610.3	601.9	8.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	853.4	822.5	30.9	950.2	948.7	1.4	1,192.2	1,182.9	9.3
Хангамж, бараа материалын зардал	72.4	73.2	-0.8	86.3	87.4	(1.1)	133.7	131.1	2.7
Норматив т зардал	1494.5	1393.9	100.6	1,514.6	1,513.1	1.6	1,572.0	1,560.8	11.2
Эд хогшил	63.1	63.3	-0.2	188.8	188.8	0.0	86.5	84.4	2.1
Томилолт, зочны зардал	5.4	4.8	0.5	4.1	3.9	0.3	4.4	3.8	0.7
Бусдаар гүйцэтгэлсэн ажил, УТХ	36.4	32.2	4.2	20.7	21.0	(0.3)	22.7	22.3	0.5
Бараа үйлчилгээний бусад зардал	153.3	154.4	-1.1	102.0	101.5	0.5	98.4	97.4	0.9
Хувийн хэвшил байгууллагад олгох татаас	319.9	319.9	0.0	317.8	317.8	-	364.7	364.7	0
Урсгал шилжүүлэг	240.9	238.3	2.5	485.4	483.4	1.9	321.1	316.0	5.1
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	175.7	173.3	2.4	70.0	70.0	-	45.8	40.9	4.9
ХОНТСА албан хаагчдад төрөөс иэилэх дэмжлэг	60.7	60.7	0.0	230.7	230.7	0.0	259.0	259.0	0.0
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	4.5	4.3	0.1	184.7	182.8	1.9	16.3	16.2	0.1
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8260.9	8003.7	257.2	8884.2	8879.1	5.1	9412.0	9362.1	49.9
Тусгай зориулалтын шилжүүлэгээс санхүүжих	8260.9	8003.4	257.5	8884.2	8879.1	5.1	9411.9716	9362.093	49.9
Туслах үйл ажиллагааны орлого	0.0	0.4	-0.4			-			

СӨБ-ын байгууллагуудын зардлын гүйцэтгэлийг аймгийн ЗДТГ-ын СТЦХ-аас санхүүжүүлэхдээ холбогдох зардлуудыг хөтөлбөр тус бүрээр нь санхүүжүүлж зарлагын гүйлгээ хийсэн, санхүүгийн тайланг эдийн засгийн ангиллаар нэгтгэн тайлагнаж байна.

Аудитаар Өлзийт сумын цэцэрлэгийн шинэ барилга 2019 оны 1-р сараас ашиглалтад орсонтой холбоотой хуучин цэцэрлэгийн барилгын ашиглалтыг шалгаж үзэхэд СӨБ-ийн үйл ажиллагаа явуулаагүй, ямар нэгэн шийдвэргүйгээр ЕБС-ийн насан туршийн боловсролын үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд халаалтын зардлыг цэцэрлэгийн төсвөөс төлж 6.7 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсныг сумын ЕБС-ийн төсвөөс төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.



35 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу жил бүр санхүүгийн жилийн эхэнд тендер зарлан шалгарсан АА-н нэгж байгууллагатай аймаг, сумын Засаг дарга гэрээ байгуулан хүнсний бүтээгдэхүүнийг цэцэрлэгүүдэд нийлүүлж байна.

Аудитад аймгийн төвийн цэцэрлэгүүдийг хамруулан бэлтгэн нийлүүлэгчидтэй хийсэн гэрээний хавсралтаас авч дундажаар үзсэн бөгөөд хоолны зардлын зонхилох хувийг эзэлж буй мах махан бүтээгдэхүүний зах зээлийн үнийг судлав.

Хүснэгт №17. Зах зээлийн үнийн судалгаа

д/д	Үзүүлэлт		2016	2017	2018
1	Зах зээлийн дундаж үнэ	Хонины мах	4839	4548.5	5565
		Ямааны мах	3925	3933	4723
		Үхрийн мах	5721	5701	6745
2	Тендерийн үнэ	Хонины мах	4706	4575	4488
		Ямааны мах	2810	3181	3156
		Үхрийн мах	5135	5082	4850
3	Зөрүү	Хонины мах	133	-27	1078
		Ямааны мах	1115	752	1567
		Үхрийн мах	586	619	1895

Аймгийн төвийн цэцэрлэгүүдийн 2016-2018 оны тендерт шалгарсан АА-н нэгж байгууллагуудын үнийн саналыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнэтэй харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал: Зах зээлийн дундаж үнийг аймгийн

Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2018 оны эмхэтгэлээс авсан болно.

Дээрх хүснэгтээс харахад мах махан бүтээгдэхүүнийг зах зээлийн үнээс тендерийн үнэ нь кг тутамд 133-1895 төгрөгөөр бага үнээр нийлүүлэгдсэн байна.

36 Баянхонгор аймгийн төвд үйл ажиллагаа явуулж байгаа цэцэрлэгүүдийн зардлын дүнг хүүхдийн тоотой уялдуулан үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт № 18. СӨБ-ын төсөв хоорондын үр ашгийн судалгаа

Зардлын зүйл	А	2018 он				
		10 -р цэцэрлэг	11 -р цэцэрлэг	12 -р цэцэрлэг	13 -р цэцэрлэг	9 -р цэцэрлэг
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1=2+3	438.7	341.5	300.2	223.1	237.7
УРСГАЛ ЗАРДАЛ	2=3+10	438.7	341.5	300.2	223.1	237.7
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3=4+5.+9	423.8	334.7	300.2	222.7	226.5
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	4	215.2	175.6	175.9	129.4	117.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5	25.8	21.0	21.8	15.5	19.3
Бусад зардал	6	8.3	15.5	11.1	9.1	4.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7	94.7	57.9	37.7	22.1	43.5
Норматив зардал	8	74.6	59.6	49.5	41.4	38.6
Тавилга	9	2.6				
Ээлжийн бүлгийн зардал	10	2.6	5.1	4.3	5.1	3.4
Урсгал шилжүүлэг	11	14.9	6.8	-	0.4	11.2
Хүчин чадал	12	200	150	150	100	75
Ажиллагсдын тоо	13	30	25	26	19	19
Хүүхдийн тоо	14	260	219	156	115	123
Гүйцэтгэлээр нэг хүүхдийн хувьсах зардал /төг/	15=(1-7-8-9-10-11)/14	968.8	968.7	1338.4	1339.5	1146.4
ЗГ-ын 2016 оны 242-р тогтоолоор/СӨБ эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын хэмжээ	16	812.3	812.3	812.3	812.3	812.3
Зөрүү	17=16-15	156.5	156.4	526.1	527.2	334.1



Дээрх хүснэгтээс харахад 260 хүүхэдтэй цэцэрлэгт батлагдсан нэг хүүхдэд ногдох хувьсан зардал 156,5 мянган төгрөгөөр илүү зарцуулагдсан байхад 123 хүүхэдтэй цэцэрлэгийн хувьд норматив зардлаас 334,4 мянган төгрөгөөр илүү хувьсах зардал гаргасан үзүүлэлт харагдаж байгаагаас үзэхэд хөрөнгө оруулалтын бодлогод төвлөрсөн хүн амтай суурин газрын хувьд 150 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн барилга баривал цаашид урсгал зардлыг бууруулах, төсвийг үр ашигтай зарцуулах боломж харагдаж байна.

37 Баянхонгор аймагт 2016-2018 онд шинээр 9 цэцэрлэг 9673.4 сая төгрөгөөр баригдсан ба орон нутгийн өмчид бүртгэлтэй 2 барилгыг засварлан ашиглаж байна.

СӨБ-ын байгууллагуудад 2016-2018 БСШУ-ны яам болон төсөл хөтөлбөр хандив тусламжаар нийт 1041,6 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдснээс 366,3 сая төгрөгийн их засварын ажил, 675,3 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил ирснийг санхүүгийн тайланд бүртгэсэн бөгөөд ашиглалтын байдал хэвийн байна.

Б.4. СӨБ-ын үйл ажиллагаанд аймгийн БСУГ-аас жилд 2 удаа хяналт хийж, арга зүйн зөвлөгөө өгч ажилладаг боловч хяналт шалгалтын тайлангүй, хяналт шалгалтын мөрөөр хийж хэрэгжүүлэх ажлын зөвлөмжийг цэцэрлэгт хүргүүлж биелэлтийг тооцож ажиллаагүй байна

Б.4.1. Зарим цэцэрлэгийн удирдлагууд Засгийн газрын 2015 оны 311 дүгээр тогтоолын дагуу “Дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам” боловсруулаагүй, ажлын төлөвлөгөө гарган төлөвлөгөөний биелэлтийг тайлагнаж ажиллаагүй байна.

38 Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 11.1¹⁴-д заасны дагуу цэцэрлэгийн удирдлага нь цэцэрлэгийн өдөр тутмын үйл ажиллагаанд удирдлагаар ханган ажиллаж байна.

Аудитаар хамран сургах тойргийн хүүхдийг сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх үндсэн болон хувилбарт сургалт зохион байгуулж ажилласан боловч хувилбар сургалтаар ажилласан багш нарын ажлын үр дүнг бүрэн тооцоогүй, мэдээ тайланг аваагүй мөн байгууллагын албан хаагчдын архив албан хэрэг хөтлөлт хяналт тавьж ажилладаггүй, архивын баримтыг дутуу хүлээж авсан байгууллагын санхүүгийн баримтыг архивт хүлээж авсан бүртгэл судалгаа байхгүй зэрэг зөрчлүүд илэрч байна. Тухайлбал:

Аудитын илрүүлэлт:

¹⁴ эрхлэгчийн бүрэн эрх үүргийн хүрээнд холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохих шийдвэрийг гаргаж, ажлын чиг үүргийг хэрэгжүүлэн цэцэрлэгийн өдөр тутмын үйл ажиллагаанд удирдлагаар хангаж ажиллах үүрэгтэй



Галуут сумын багш журналыг бүрэн хөтлөөгүй орхисон байхад хүлээж авсан, мөн 2016 оны 1 багшийн журнал байхгүй, Эрдэнэцогт сумын 2016 оны 2 бүлгийн 2018 оны 1 журнал байхгүй, 2016, 2017 оны бэлтгэл, ахлах бүлгийн журналыг багш нараас авч архивт хүлээн аваагүй.

Шинэжинст, Жинст, Баянлиг, Эрдэнэцогт, Баян-Овоо, Бууцагаан, Баянбүрд багийн цэцэрлэгийн төсвийн төсөл, төсвийн хуваарийг бүрэн хүлээж аваагүй, Баацагаан, Баянговь, Богд, Баян-өндөр, Галуут, Бөмбөгөр, Өлзийт сумын цэцэрлэгүүдийн төсвийн анхны батлагдсан хуваарийг өгөлгүйгээр зөвхөн өөрчлөлт орсон хуваарийг архивт хүлээлгэж өгсөн нийтлэг зөрчил илэрч байна.

Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах Засгийн газрын 2015 оны 311 дүгээр тогтоолын дагуу аудитад хамрагдсан улсын 29, хувийн өмчийн 7 цэцэрлэгээс 24 цэцэрлэг өөрийн үйл ажиллагаанд нийцүүлэн “Дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам” боловсруулж эрхлэгчийн тушаалаар баталж, дотоод хяналт шалгалт хариуцсан ажлын хэсэг болон ажилтан томилон ажиллуулж, ажлын төлөвлөгөө гарган төлөвлөгөөний биелэлтийг тайлагнаж хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг аймгийн мэргэжлийн хяналтын байгууллагад улирал бүр хүргүүлэн ажилласан байна.

Аудитын илрүүлэлт:

Харин Шинэжинст, Жинст сумын цэцэрлэг хяналтыг хэрэгжүүлээгүй, Баянбүрд багийн бага цэцэрлэг, Баян-овоо сумын цэцэрлэгүүд дотоод хяналт ажилтан томилсон боловч дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлэх журам, төлөвлөгөө тайлан байхгүй, Богд, Галуут сумын цэцэрлэгийн 2016 онд дотоод хяналтын төлөвлөгөө, тайлан байхгүй.

Иймд дотоод хяналт шалгалтыг хууль журамд заасны дагуу зохион байгуулж, үйл ажиллагаан байнгын хяналт тавьж ажиллахад нь арга зүйн зөвлөгөө өгч түүндээ хяналт тавьж ажиллахыг аймгийн БСУГ-т зөвлөв.

39 Сургууль цэцэрлэгийн зөвлөлийг Баянлиг, Баянцагаан, Бууцагаан сумын цэцэрлэгүүд, аймгийн төвийн 6, 9, 5-р цэцэрлэгүүд байгуулсан боловч үйл ажиллагаа явуулсан эсэх нь тодорхойгүй, чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аудитын илрүүлэлт:

Харин бусад цэцэрлэгүүд нь цэцэрлэгийн зөвлөл байгуулаагүй нь Сургуулийн өмнөх боловсролын тухай 10.2¹⁵ –д заасан заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

¹⁵ цэцэрлэгийн өөрийн удирдлага нь цэцэрлэгийн зөвлөл байх бөгөөд түүнийг Боловсролын тухай хуулийн 35 дугаар зүйлд сургууль, цэцэрлэгийн зөвлөл нь багш, ажилтан, сурагч, эцэг, эх, бусад байгууллагын төлөөллийн 9-11 гишүүнтэй сургууль, цэцэрлэгийн зөвлөлийг 3 жилийн хугацаатай сургууль, цэцэрлэгийн нийт ажилтны хурлаас сонгоно



Аудитын явцад улсын 29 цэцэрлэгийн 2215, хувийн өмчийн 3 цэцэрлэгийн 126 эцэг, эхээс “Танай хүүхдийн цэцэрлэгт зөвлөл ажилладаг уу?” гэсэн асуулгаар санал авахад 62,4 хувь буюу 1463 иргэн “тийм”, “Цэцэрлэгийн эцэг эхийн зөвлөлөөс тавьж буй хяналт эцэг эхчүүдэд ил тод нээлттэй байна уу?” гэсэн асуулгад 76,0 хувь буюу 1784 иргэн “ил тод нээлттэй” гэж хариулсан байна.

График № 5 Улсын цэцэрлэгт хүүхэд нь хамрагдаж буй эцэг эхчүүдээс авсан судалгаа




График № 6 Хувийн өмчийн цэцэрлэгт хүүхэд нь хамрагдаж буй эцэг эхчүүдээс авсан судалгаа



Цаашид цэцэрлэгийн зөвлөлийг хууль журамд заасны дагуу зохион байгуулж, үйл ажиллагаа явуулах байнгын хяналт тавьж ажиллахад нь арга зүйн зөвлөгөө өгч түүндээ хяналт тавьж ажиллахыг аймгийн БСУГ-т зөвлөв.

40 Цэцэрлэгийн үйл ажиллагааны хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх эцэг, эхийн цэцэрлэгийн хамтын ажиллагаа сайжруулах чиглэлээр цэцэрлэгийн эцэг эхийн зөвлөлийг Баянлиг, Өлзийт, Бөмбөгөр, Бууцагаан сумын цэцэрлэг, Баянхонгор сумын 1,3,5,6,7,9,11,12,13,15-р цэцэрлэгүүд, хувийн өмчийн Гэгээхэн цэцэрлэг эцэг эхийн зөвлөл байгуулсан, бусад цэцэрлэгүүд байгуулаагүй байна.

Баянхонгор сумын 1,5-р цэцэрлэг, Өлзийт, Баянлиг, Бөмбөгөр эцэг, эхийн зөвлөл нь төлөвлөгөө гарган ажиллаж хэрэгжилтийг жилд 2 удаа нийт эцэг эхийн хуралд танилцуулж ажилласан байна.

**Аудитын илрүүлэлт:**

Өлзийт, Баянлиг, Бөмбөгөр сумын цэцэрлэг, Баянхонгор сумын 1, 5-р цэцэрлэгийн эцэг эхийн зөвлөл нь цэцэрлэгт хөндлөнгийн үнэлгээ хийх, багш нарын хичээлд суух, хоолны амт чанарт хяналт тавьж ажилласан, бусад цэцэрлэг нь эцэг эхийн зөвлөл байгуулсан боловч үйл ажиллагаа нь тогтмолжоогүй цэцэрлэгээс зохион байгуулж буй олон нийтийн арга хэмжээнд оролцох зэргээр ажиллаж хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Аудитын хүрээнд цэцэрлэгт хүүхэд нь хамрагдаж буй улсын 29 цэцэрлэгийн 2215, хувийн өмчийн 3 цэцэрлэгийн 126 эцэг, эхээс авсан санал асуулгаар Та хүүхдийнхээ цэцэрлэгийн үйл ажиллагаанд хяналт тавьдаг уу? гэсэн асуултад дийлэнх нь:

- багштай нь хамтарч ажилладаг
- тэр бүр хяналт тавьж чаддаггүй
- үйл ажиллагаанд хяналт тавих боломжгүй
- хяналтын камераар л харж хяналт тавьдаг
- цэцэрлэгийн анги танхимын тохижилтод л хяналт тавьдаг бусад үйл ажиллагаанд тавьдаггүй гэсэн хариултыг өгсөн байна.

Иймд цэцэрлэгийн эцэг эхийн зөвлөлийг байгуулж, хөндлөнгийн хяналт тавих орчинг бүрдүүлэхэд арга зүйн зөвлөгөө өгч түүндээ хяналт тавьж ажиллах зөвлөмжийн аймгийн БСУГ-т зөвлөв.

Б.4.2. СӨБ-ын үйл ажиллагаанд аймгийн МХГ нь төлөвлөгөөт шалгалтыг байнга хийж ажилласан бөгөөд харин БСУГ-аас жилд 2 удаа хяналт хийж, арга зүйн зөвлөгөө өгч ажилладаг гэх боловч хяналт шалгалтын тайлангүй, хяналт шалгалтын мөрөөр хийж хэрэгжүүлэх ажлын зөвлөмжийг цэцэрлэгт хүргүүлж ажиллаагүй байна.

41 Аймгийн Боловсрол соёл урлагын газар нь боловсрол, төрийн бодлогын нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэхтэй холбогдуулан сургуулийн өмнөх боловсрол олгож буй төрийн болон хувийн өмчийн цэцэрлэгүүдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэх, багш, туслах багшийн мэргэжлийг дээшлүүлэх, хууль тогтоомж, дүрэм журам стандартыг хэрэгжүүлэх зорилгоор сургуулийн өмнөх боловсрол үйл ажиллагаанд жилд 2 удаа хяналт шалгалт болон зөвлөн туслах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна.

2017 онд Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар төрийн өмчийн 29 цэцэрлэгийн эрхлэгчийн тайланг хэлэлцэж, БСУГ-аас цэцэрлэгийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийсэн бөгөөд Баянхонгор сумын 2,6,7,9-р цэцэрлэгийн сургалтын хөтөлбөрт хяналт хийхэд, холимог насанд тохирохгүй, 11-р цэцэрлэгийн хөтөлбөрийн агуулга дутуу төлөвлөгдсөн мөн 11 дүгээр цэцэрлэг нь



ээлжийн бүлэгт хамрагдаж буй хүүхдүүдийг үндсэн бүлэгтэй хольж нэг болгосон зэрэг зөрчлүүдийг арилгах арга хэмжээ авч ажилласан байна.

2018 онд Явуулын багшийн сургалтын чанарыг сайжруулах ажлын хүрээнд Гурванбулаг, Заг, Жаргалант, Галуут, Өлзийт сумын цэцэрлэгт ажиллаж буй явуулын багш нарын явуулж буй сургалт, эцэг эхтэй хамтран ажиллаж буй ажлын явцад хяналт хийж ажиллахад дараах зөрчил илэрсэн байна.

Галуут сумын явуулын багшийн гэрийн эргэлтийн тэмдэглэл дутуу, ирцийн бүртгэлгүй цэцэрлэгийн эрхлэгч хяналт тавиагүй. хувилбарт сургалтад 3-аас доош насны хүүхэд авахгүй байхад Заг сумын цэцэрлэгт 1,5- 1,8 настай хүүхдийг 24 цагийн сургалтад хамрагдаж байгаа нь эрсдэл үүсэх асар өндөр магадлалтай байна гэсэн дүгнэлт өгчээ.

42 Баянхонгор аймгийн хэмжээнд “Сайн багш” хөтөлбөр, “Хос бичигтэн” хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа бөгөөд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад аймгийн БСУГ хяналт тавьж ажиллаж байна.

Дээрх хөтөлбөрүүдийн үр дүнг аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд оруулан үр дүнг жил бүр аймгийн ИТХ-д тайлагнаж биелэлтийг 100 хувь гэж үнэлсэн байна.

43 БСУГ-аас цэцэрлэгүүдэд хийсэн мониторингийн мөрөөр өгсөн зөвлөмжийн хүрээнд цэцэрлэгүүд ирцийн бүртгэлийн дэвтрийг тусгайлан гаргасан, гал тогоонд мөрдөгдөж буй хүүхдийн тооны дэвтэрт ээлжийн бүлгийн хүүхдийн ирцийг ялгагдахаар тэмдэглээгүй, ирцийн бүртгэл Баянхонгор сумын 4, 5-р цэцэрлэг дээр дутуу бичигдсэн зөрчлийг бүрэн арилгасан бөгөөд сургалт явуулж буй танхимын талбайн хэмжээ хэт бага өрөөг солих шаардлагатай байсныг 4-р цэцэрлэгийг гэр бүлгээр, 5-р цэцэрлэгийн танхимыг хоёрдугаар давхрын дуу хөгжмийн зааланд сургалтын үйл ажиллагааг явуулах зааварчилга өгч зөрчлийг арилгасан байна

Хаврын улиралд 24 цагийн үйл ажиллагаатай нүүдлийн бүлгийн сургалт зохион байгуулж буй Бууцагаан сумын Наран баг, Хүрээмарал сумын Хөх бүрдний баг, Бөмбөгөр сумын Хөх эргийн багт гарч цэцэрлэгийн үйл ажиллагаанд БСУГ-ын сургалт аргазүйн хэлтсийн дарга, мэргэжилтэн, аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн боловсрол хариуцсан боловсролын мэргэжилтэн нар хамтарсан хяналт хийж зөвлөн туслах ажлыг зохион байгуулахад хоол хүнсний аюулгүй байдал ялангуяа тээвэрлэлт хадгалалт, цаг агаарын болон болзошгүй нөхцөл байдалд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлт хийх, хэрэгжүүлэгч оролцогч талуудын үүрэг



оролцоо, багийн засаг дарга, эмчтэй хамтран ажиллах эргэлтийн хугацааг тодорхой болгох, эцэг эх нь хүүхдийн хувцас солих хувцсыг бэлтгэдэг байх, Баасан гаригт хүүхдээ заавал хүлээн авах, байнгын холбоотой байх, түлшний асуудлыг бүрэн шийдвэрлэх санхүүжилтийг цаг тухайд нь олгох зэрэг асуудлаар ярилцлага хийж Сумын болон багийн засаг дарга, цэцэрлэгийн нягтлан бодогч, эрхлэгч, эцэг эхийн төлөөлөлтэй хамтран шийдвэрлэсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Гэвч аудитад хамрагдсан цэцэрлэгийн эрхлэгч нар аймгийн БСУГ-аас сургуулийн өмнөх боловсрол хариуцан мэргэжилтэн жилд 2 удаа цэцэрлэгүүдэд ажиллаж, хяналт хийж арга зүйн зөвлөгөө өгч ажилладаг гэсэн боловч тухайн цэцэрлэгт хяналт шалгалтын тайланг хуулбарлаж хүлээлгэж өгдөггүй, хяналт шалгалтын мөрөөр хийж хэрэгжүүлэх ажлын зөвлөмжийг албан ёсоор цэцэрлэгт хүргүүлж ажиллаагүй байна.

Энэ талаар БСУГ-аас сургуулийн өмнөх боловсрол хариуцсан мэргэжилтэнээс тодруулахад: “хяналтын тайланг мэдээг нэгтгэн гаргаж цэцэрлэгийн эрхлэгчдийн нэгдсэн цахимаар хүргүүлж, өмнө өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг дараа хяналт шалгалтаар биелэлтийг үзэж шалгадаг” гэсэн тайлбар өгсөн.

Боловсрол соёл урлагын газраас хяналтыг хэрэгжүүлж байгаа боловч Багш ажилчдын хувийн хэргийн бүрдэл хангалтгүй, багш журналын хүүхдийн ирцийг бүрэн хөтлөгдөөгүй, хүүхэд өдрийн гүйцэтгэл тодорхой биш, хувилбар сургалтын үр дүнг бүрэн тооцож ажиллаагүй, мэдээ тайланг архивт хүлээлгэж өгөөгүй, СӨБ-ын статистик мэдээллийн сан зөрүүтэй, тухайн цэцэрлэгт хамрагдах боловч өөр цэцэрлэгийн статистик мэдээнд бүртгэлтэй гэх мэт зөрчил илэрч байна.

Иймд СӨБ-ийн байгууллагад хяналт хийж, арга зүйгээр хангаж ажиллахдаа тухай бүр нь баримтжуулж, зөвлөмжийн мөрөөр хийсэн ажлын биелэлтийг тооцож ажиллах зөвлөмжийг аймгийн БСУГ-т хүргүүлэв.

44 Мэргэжлийн хяналтын газар даргын 2017 оны 01/139 тоот нэгдсэн удирдамжаар сургуулийн өмнөх боловсрол үйл ажиллагаа явуулж буй 36 цэцэрлэг үүнээс хувийн өмчийн 4 цэцэрлэг, хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь хууль болон тэдгээрт нийцүүлэн гаргасан стандарт дүрэм журмын хэрэгжилтийг хангах, өнөөгийн түвшинг тогтоох, үнэлгээ дүгнэлт өгөх чиглэлээр хяналт шалгалтыг зохион байгуулжээ.

Хоол үйлдвэрлэлийг шалгах хяналтын хуудсаар аймгийн төвийн цэцэрлэгүүдийг үнэлэхэд Баянхонгор сумын 5, 12, 3 дугаар цэцэрлэгүүд бага эрсдэлтэй 6, 7, 2, 4 дүгээр цэцэрлэг, хувийн өмчийн “Гэгээхэн”, “Эко”, дунд



эрсдэлтэй, хувийн өмчийн Тэргэл цэцэрлэг их эрсдэлтэй гэж үнэлэгдсэн ба илэрсэн зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлж хэрэгжилтийг тооцож ажиллажээ.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын тандалт судалгааны удирдамжаар газрын 2018.03.01-ний өдрийн 02/113 тоот удирдамжаар орон нутгийн цэцэрлэгүүдийн үйл ажиллагаанд эцэг, эхчүүдийн оролцооны байдал, бодлого төлөвлөлтөд санал өгөх, мэдээлэл чөлөөтэй авах, хяналт тавих нөхцөл бүрдсэн эсэхэд тандалт судалгаа хийж Баянхонгор сумын 7 цэцэрлэгийн 30 бүлгийн 150 эцэг, эх асран хамгаалагчийг хамруулан санал асуулгад хамруулж ажиллажээ.

Мөн 2018 онд Баянхонгор сумын 4,7,14,15 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалтыг явуулж шалгалтаар “Нэг багшид ногдох хүүхдийн тоог норм, нормативт нийцүүлэх, гадна тоглоомын биеийн тамирын талбайд тавигдах шаардлага хангаагүй, хоол үйлдвэрлэлийн технологийн шат дамжлагын үеийн шаардлагатай өрөө тасалгаатай болох, цэцэрлэгийн орчны үнэлгээ хийлгэх, түүхий эд бүтээгдэхүүн хадгалах, хөргөх, төхөөрөмжийн температурыг хянаж бүртгэл хөтлөх, хүүхдийн тоглоом нь аюулгүй байдлын шаардлага хангасан баталгаажилтын бичигтэй байх” зэрэг зөрчил илэрч зөрчлийг арилгах албан хүргүүлж, биелэлтийг тооцож ажилласан байна.

45 СӨБ-ын байгууллагуудад аймгийн БСУГ болон МХГ-аас шалгалт, өгсөн зөвлөмжийн мөрөөр тухай бүр нь биелэлтийг гаргаж дараах арга хэмжээ авч ажилласан байна. Үүнд:

- ✓ 2017 онд Баянхонгор суманд цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа 314 хүүхдийг ээлжийн бүлгээр сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг 72 цагийн багтаамжтайгаар олгохоор сургалтын хөтөлбөр гаргасан.
- ✓ Баянхонгор аймгийн 2,6,7,9-р цэцэрлэгийн сургалтын хөтөлбөрийн агуулгыг задлан шинжлэхэд агуулга нь холимог насанд хүндсэн, 9-р цэцэрлэгийн агуулга нь хэт хөнгөдсөн, 11-р цэцэрлэгийн агуулга дутуу төлөвлөгдсөнийг засаж сайжруулсан.
- ✓ Өмнөх жилд өгөгдсөн санамжийн дагуу ирцийн бүртгэлийн дэвтрийг тусгайлан гаргасан боловч гал тогоонд мөрдөгдөж буй тооны дэвтэрт ээлжийн бүлгийн хүүхдийн ирцийг ялгагдахаар тэмдэглээгүй, ирцийн бүртгэл 4,5-р цэцэрлэг дээр дутуу бичигдсэн, сургалт явуулж буй танхимын талбайн хэмжээ хэт бага өрөөг солих шаардлагатай байсныг 4-р цэцэрлэгийг Гэр бүлгээр, 5-р цэцэрлэгийн танхимыг хоёрдугаар давхрын дуу хөгжмийн зааланд сургалтын үйл ажиллагаа явуулах зааварчилгаа өгч зөрчлийг арилгасан.

Харин аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн боловсрол хариуцсан мэргэжилтэн 2018 онд Баянхонгор сумд үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн өмчийн цэцэрлэгүүдэд хяналт, шинжилгээ, үнэлгээ, зөвлөн туслах үйлчилгээ



үзүүлж ажилласан бөгөөд хяналт шалгалтаар цаашид анхаарч ажиллах 13 заалт бүхий зөвлөмжийг гаргаж хүргүүлсэн боловч хэрэгжилтийг тооцоогүй байна.

Аудитаар нийт 23,8 сая төгрөгийн зөрчил илэрч төлбөрийн акт тогтоов.

АУДИТЫН ТАЙЛАНТАЙ ХОЛБОГДУУЛАН УАГ-ЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ГАЗАРТ ДАРААХ САНАЛЫГ ХҮРГҮҮЛЖ БАЙНА.

1. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа холбогдох хуульд заасан дагуу батлагдвал зохих дүрэм журмыг боловсруулан цаашид зөрчилдөж байгаа дүрэм, журам хөтөлбөрийн холбогдох заалтын зөрчлийг арилгах.
2. Хүүхдийн цэцэрлэгийн захиргаа-үйлчилгээний ажилтны орон тооны үлгэрчилсэн нормативыг гаргаж цаашид мөрдүүлж ажиллах саналыг уламжилж байна.
3. Удирдлагын зөвлөлийн хурал аймгийн Боловсрол соёл урлагийн газрын дарга, мэргэжилтэн нар аймгийн хэмжээнд мэргэжлийн хоол зүйч ажиллуулах саналыг уламжилж өгөхийг хүссэн.

**Холбогдох байгууллагын санал:**


МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
64101 Номгон, Баянхонгор сум
Вэбсайт: www.bayankhongor.gov.mn
Утас/Факс: (976) 70-44-22-73

2019.11.01 № 4/1336
танай _____ -ны № _____ -т

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Санал хүргүүлэх тухай

Төрөөс сургуулийн өмнөх боловсрол олгож буй өнөөгийн байдал үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж буйд Нийгмийн бодлогын хэлтсээс бодлогын хүрээнд сургуулийн өмнөх боловсролын асуудлаар дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Сургуулийн өмнөх боловсролын салбарт ажиллагсдын жишиг нормативыг шинэчлэн тогтоох, мөрдүүлэх.
2. Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль бусад хуулиудад сургуулийн өмнөх боловсролын салбарт ажиллагсдын ажлын ачаалал илүү цагаар ажилласан хөлсийг тооцон олгох талаар тусгах.
3. Сургуулийн өмнөх боловсролын биеийн тамир, хөгжмийн боловсролын багш нарыг мэргэшүүлэх тогтолцоог хуульчилах.
4. Сургуулийн өмнөх боловсролын сургалтын нэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөөг БСШУС-ын яамнаас батлах.

НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН-ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ЭНХЖАРГАЛ



1191400

D:\2019 он\Тамгын газар\Тамгын газрын тоот А4-2019 он.docx



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР**
64101 Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Номгон баг
Утас 70-44-21-15

2019.10.31 № 281

танай _____-ны № _____-т

Г АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ 7

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын
2016-2018 оны үйл ажиллагаанд хийсэн гүйцэтгэлийн
аудитын дэд тайлантай танилцаад дараах саналыг
хүргүүлж байна.

Хавсралт 1 хуудастай.

ДАРГА

М.МӨНХБАТ



8419346



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДЭД ТАЙЛАНД ӨГӨХ САНАЛ

2019 оны 11 дүгээр сарын 01

Номгон

1. 2016-2017, 2017-2018 оны хичээлийн жилд СӨБ-ын сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр Үндэсний болон орон нутгийн баг нь 8 удаагийн сургалт, зөвлөлдөх уулзалт-2, багш нарыг хөгжүүлэх аргазүйн зөвлөгөө-үзүүлэх ажил, сайн үйл ажиллагааг зохион байгуулж давхардсан тоогоор 338 багш, эрхлэгч оролцсон бөгөөд энэ ажлын хүрээнд /бүс, аймаг, улсын зөвлөгөөнд оролцогчдыг шалгаруулах /Баянцагаан, Бууцагаан, Өлзийт, Баянлиг, Баянхонгор сумын 4, 9, 7, 1, 5 дугаар цэцэрлэгийн сурган хүмүүжүүлэх үзэл баримтлал, сургалтын хөтөлбөр нь тавигдаж буй шаардлагад нийцсэн, хүүхдийн хөгжлийг дэмжсэн орчинг бүрдүүлж чадсан. Мөн нийт оролцогч нарын 80-аас дээш хувийн саналыг авч чадсан багш нарын сургалтын хөтөлбөр, хүүхдийн хөгжлийн ахицыг илэрхийлэх тоглоомын сангаар сайн туршлагуудыг илрүүлж 2016 онд "Хүүхэд бүрийн хөгжилд-бидний оролцоо", 2017 онд Баянхонгор сумын 4-р цэцэрлэгийн үзэл баримтлалын хэрэгжилтийг илэрхийлсэн "Монгол наадгай", 2017 онд "Багшлах аргазүй" багш нарын арга туршлагын эмхэтгэлийг гарган цөм хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зөвлөмж материалыг цэцэрлэг тус бүрд хүргүүлсэн байна. /цэцэрлэгийн эрхлэгч нар гарын үсэг зурж хүлээн авсан байна/

2.Эрдэнэцогт сумын 1 дүгээр багт аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтад түшиглэсэн цэцэрлэгийн салбар бүлгийн халаалтын асуудлыг хүрэн ЖИНСНИЙ ОВОО ХХК нам даралтын уурын зуухаар шийдвэрлэн улсын коммист урьдчилан хүлээлгэн өгсөн байна.

3.Хүүхдийн ахицын үнэлгээг тухайн хүүхэдтэй ажилласан бүлгийн багш локаль программд 135 багш шивж оруулсан бөгөөд үүнээс 78 багшийн программ устсан нь эдгээр багшид хүндрэл учруулж байсан бол 2018 онд огт байхгүй болсон байна.

4.Мэргэжлийн багшийн хэрэгцээний судалгааг 2013 онд гаргаж, шинээр баригдах цэцэрлэгүүдийн төлөвлөлттэй уялдуулан 2014 -2015 онд СӨБС-ийн хөрвөх ангид 30, Сэрүүлэг дээд сургуульд 18 мэргэжлийн багшийг бэлтгэсэн. Нийт багш нарын 56-70 орчим хувийг 35 хүртэлх насны багш нар эзэлж байгаа ба тухайн багшийг жирэмсний амралт авахад /2 жилийн хугацаанд / өөр мэргэжлийн болон тэтгэвэрт гарсан багш авч ажиллуулж байна.

САНАЛ НЭГТГЭСЭН
МЭРГЭЖИЛТЭН

Б.ОЮУНГЭРЭЛ

ХЯНАСАН
ДАРГА

М.МӨНХБАТ



Саналд өгсөн тайлбар:

Ирүүлсэн санал, баримт материалд үндэслэн дараах тайлбарыг өгч байна.

1. Аймгийн ЗДТГ-ын газраас ирүүлсэн саналын Сургуулийн өмнөх боловсролын салбарт ажиллагсдын жишиг нормативыг шинэчлэн тогтоох мөрдүүлэх буй тусгасан саналыг ҮАГ-т уламжлав.
2. Бусад ирүүлсэн саналууд өмнө нь тайланд тусгагдсан.



ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид заагдсан эрх бүхий субъект нь зарим дүрэм журмыг батлаагүй, батлагдсан зарим журам, хөтөлбөр нь хоорондоо зөрчилдөж байна.

2. Төрөөс сургуулийн өмнөх боловсролын талаар авч хэрэгжүүлж байгаа бодлого харилцан уялдаатай боловсруулагдаж, удирдлагын болон санхүүгийн тогтолцоо чиг үүрэг нь хуульд заасны дагуу зохион байгуулагдсан байна.

3. Сургуулийн өмнөх боловсролд олгох үйлчилгээг бодитой төлөвлөн, төрөөс хүүхдийн хамрагдалтыг сайжруулах бодлого барьж ажилласны үр дүнд Баянхонгор аймгийн хэмжээнд сүүлийн 3 жилд хүртээмж сайжирч, хамрагдалт 90,9 хувьд хүрсэн байна.

4. Сургуулийн өмнөх боловсролыг цөм хөтөлбөрийн агуулгын дагуу олгож чадвар эзэмшүүлж байна.

5. Хөдөө сумдад мэргэжлийн боловсон хүчний хүрэлцээ хангалтгүй дутмаг байгаагаас багшид тавих шаардлагыг хангаагүй, мэргэжлийн бус багш ажиллуулж байна.

6. БСУГ-т цэцэрлэгүүдийн бэлтгэл бүлгийн стандарт хангалт, ахиц амжилтын түвшний мэдээллийг нэгтгэн дүн шинжилгээ хийгээгүй байна.

7. Хувийн өмчийн цэцэрлэгүүдэд санхүүжилт олгохдоо гүйцэтгэлд хяналт тавьж баталгаажуулаагүйгээс хүүхдийн хувьсах зардлыг илүү олгожээ.

8. Зарим цэцэрлэгийн удирдлагууд Засгийн газрын 2015 оны 311 дүгээр тогтоолын дагуу “Дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам” боловсруулаагүй, ажлын төлөвлөгөө гарган төлөвлөгөөний биелэлтийг тайлагнаж ажиллаагүй байна.

9. Сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагаанд аймгийн БСУГ-аас жилд 2 удаа хяналт хийж, арга зүйн зөвлөгөө өгч ажилладаг боловч хяналт шалгалтын тайлангүй, хяналт шалгалтын мөрөөр хийж хэрэгжүүлэх ажлын зөвлөмжийг цэцэрлэгт хүргүүлж биелэлтийг тооцож ажиллаагүй байна.

**ЗӨВЛӨМЖ:**

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Г.БАТЖАРГАЛ, ЗДТГ-ЫН СТСХ-ИЙН ДАРГА С.БАЙГАЛМАА ТАНАА:

1. Сургуулийн өмнөх боловсролын нэг хүүхдэд ногдох хувьсах зардлыг нормативт зардлаар тооцон олгож хүүхдийн цэцэрлэгийн захиргаа-үйлчилгээний ажилтны орон тооны үлгэрчилсэн нормативыг баримталж, төсвийн шууд захирагчийн төсвийн гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллах.

2. Хувийн өмчийн цэцэрлэгүүдэд санхүүжилтийг Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолыг мөрдөж, гүйцэтгэлийг хянан баталгаажуулж, холбогдох нэхэмжлэлийг үндэслэн санхүүжилтийг гүйцэтгэлээр нь олгож байх.

АЙМГИЙН БОЛОВСРОЛ СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГА М.МӨНХБАТ ТАНАА:

1. Хууль журамд заасны дагуу сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад дотоод хяналт шалгалтыг бүтэцийг бий болгож, үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж ажиллахад нь арга зүйн зөвлөгөө өгч, хяналт тавьж ажиллах.

2. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын үйл ажиллагаанд хяналт хийж, арга зүйгээр хангаж ажиллахдаа тухай бүр нь баримтжуулж, зөвлөмжийн мөрөөр хийсэн ажлын биелэлтийг тооцож байх.

АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАРТ:

1. Эрүүл мэндийн үзлэгт багш ажилчдыг бүрэн хамрагдаж байгаа эсэхэд хяналт тавьж бүрэн хамруулж ажиллах.

2. БСУГ-т цэцэрлэгүүдийн сургалтын стандарт хангалт, ахиц амжилтын түвшний мэдээллийг нэгтгэн дүн шинжилгээ хийж буй эсэхэд хяналт тавьж ажиллах.